

МОНГОЛ УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫГ ҮР АШИГТАЙ АШИГЛАХ АСУУДАЛД

“Нээлттэй Нийгэм Форум”-ын санал болгосны дагуу боловсруулсан санал зөвлөмж

БАЙГАЛИЙН БАЯЛАГ ХЯСЛАН БОЛОХ УЧИРГҮЙ

Монгол улс ашигт малтмалын ордын хувьд баян улсад хамаарна. Зэс, алт, мөнгө, нүүрс, уран, төмөр зэрэг ашигт малтмалын одоогоор илрүүлээд байгаа ордын нийт нөөц, түүний ашиглалтаас олж болох ашиг хуримтлалын Монгол улсын нэг хүнд оногдох хэмжээ их гэж тооцогддог. Эрэл хайгуулын ажлыг өрнүүлж эрэлт ихтэй ашигт малтмалын шинэ ордууд нээх магадлал бий.

Олон Улсын Валютын Сангаас 2004 онд ашигт малтмалаар баян орон гэж үзвэл зохистой шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон бөгөөд, түүндээ уул уурхайн үйлдвэрийн бүтээгдэхүүнээс улсын төсөвт оруулж байгаа орлого, мөн энэ салбарын бүтээгдэхүүний

экспортод эзэлж байгаа хувь нь тус тус 25-тай тэнцүү байх гэж үзсэн гэдэг. Монгол улсын хувьд эдгээр үзүүлэлт 25 хувиас дээгүүр бөгөөд ойрын ирээдүйд нэмэгдэх боломжтой.

Байгалийн баялаг дээр тулгуурласан эдийн засагтай улс хөгжих ирээдүйгүй гэж ярих хүн дайралддаг. Баялаг ихтэй улсын төр засаг нь улс орныхоо эдийн засаг нийгмийг хөгжүүлэх сонирхлоор Байгалийн баялаг ашигласны орлого ашгийг бодитойгоор тодорхойлж, төр ба хөрөнгө оруулагч компанийн хооронд хуваарилах зохистой харьцааг тогтоох, хөрөнгө мөнгөний урсгалыг зөв зохицуулах, төрийн мэдэлд хуримтлагдсан хөрөнгийг ухаалаг ашиглах асуудлыг зохистой шийдэж чадсан хуультай, тэр хуулиа тууштай хэрэгжүүлдэг байхгүй бол Байгалийн баялгаа гаднын



компанид ашиглуулаад улс орондоо үлдээсэн хуримтлал, бэлтгэсэн боловсон хүчингүй, сүйтгэгдсэн байгаль орчинтой хоцрогдсон улс болж үлдэж болохоос болгоомжил гэж байгаа хүний үг.

Монголын нийгмийн зүгээс сүүлийн жилүүдэд монголын байгалийн баялаг ашигласны орлого ашгийг бүрэн хуримтлуулж, ядуурлыг бууруулж, улс нийгмийг хөгжүүлэх арга хэмжээнд зориулах нөхцөл бүрдүүл, авилга хахуулиар завшигдахаас сэргэмжил гэсэн шаардлага хурц хэлбэрээр тавигдаж байна. Энэ бол “нөөц баялгийн хяслан” гэгчээс болгоомжилж чадсан байхыг ард түмний зүгээс төр засагтаа тавьж байгаа зүй ёсны шаардлага юм.

ОЛБОРЛОХ САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫН АЧ ХОЛБОГДОЛ

Зарим улс оронд, ялангуяа хөгжиж байгаа улсад ашигт малтмалын олборлолтоос олж байгаа орлого ашиг ил тод биш, тэр нь улсын нь хөгжилд, ядуурлыг бууруулахад зориулагддаггүй, авилга, элдэв зөрчлөөр завшигдах явдал гарсаар байгаа нь дэлхий нийтийн анхааралд авагджээ.

Алив баялгийн орд газрын ашиглалт, түүнээс орж байгаа орлого ашиг, түүний хуваарилалтыг ил тод байлгах, түүний зохистой ашиглалтын төлөө Засгийн газар хариуцлага хүлээдэг байлгахын төлөө Төрийн байгууллагууд, Хөрөнгө оруулагч хувийн

салбарынхан болон Иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажилладаг болгох хөдөлгөөн - санаачилгыг дэлхийн зарим улс орон дэмжин оролцож байна.

Их Британи улсын Ерөнхий сайд Тони Блейр, Норвегийн Ерөнхий сайд Женс Столтенберг нар 2002 онд санаачилж, олон улс орон дэмжин хэрэгжүүлж байгаа **“Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачлага”** /товчилсноор **ОСИТБС/** гэж нэрлэж байгаа, уул уурхайн үйлдвэрлэлд ил тод, хариуцлагатай байдлыг бий болгох зорилготой хамтын ажиллагаанд Монгол улс нэгдэн орж идэвхтэй ажиллах нь зүйтэй юм.

ОСИТБС нь Монголын ашигт малтмалын ордыг ашиглахтай холбогдсон санхүү эдийн засгийн нөхцөл, төлбөр тооцоо, үр ашиг, ашгийн хуваарилалт ашиглалтыг ил тод байлгах, орлого ашгийн ихэнх хэсгийг Монголдоо үлдээж зохистой ашиглах талаар монголын иргэдээс засгийн газартаа тавьж буй шаардлагатай нийцэж байгаа.

Олон улсын байгууллагын туршлагаас суралцаж, дэмжлэг авч ОСИТБС- ыг амжилттай хэрэгжүүлбэл, тэр нь:

- Засаглалыг сайжруулах хүч чармайлтыг тодорхой үр дүнд хүргэх ажил болно.
- Нөөц баялгийн ашиглалтаас орох орлогын удирдлагыг сайжруулаад зогсохгүй эдийн засаг, улс төрийн тогтвортой байдлыг бий болгоход сайнаар нөлөөлнө.

- Уул уурхайн салбартай холбогдсон алив зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд тус дөхөм үзүүлнэ.

- Засгийн газар нь ил тод байдлын төлөө ажилласнаар хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлнэ.

Монгол улс ОСИТБС-ын зарчмыг баримтлан амжилттай хэрэгжүүлж Ашигт малтмалын ашиглалтаас гарах орлого ашгийг бодитойгоор тодорхойлох, түүний хуваарилалтыг сонирхогч талуудын эрх ашгийг бодолцсон шударга зарчмаар хуваарилан улс нийгмийг хөгжүүлэх ашиг сонирхолын дагуу ашиглах, энэ бүхний хэрэгжилтэд Монголын иргэдийн зүгээс хяналт тавьж байх нөхцөл бүрдүүлсэн хууль эрх зүйн акттай болох, ашигт малтмалын ордыг ашиглах талаар хувийн компанитай гэрээ байгуулахад ил тод байх асуудлыг нөхцөл болгодог болох зэрэг асуудлыг шийдэхэд эерэгээр нөлөөлөх болно.

Стратегийн ач хобогдолтой ашигт малтмалын ордын ашиглалтад Монголын төр хөрөнгө оруулах, орд ашиглаж буй компанийн удирдлагад төрийн төлөөллийн хүмүүсийг заавал оролцуулах, иргэний нийгмийн зүгээс хяналт тавих нөхцлийг бүрдүүлж өгөх явдал ил тод шударга үнэн байдлыг хангах чухал нөхцөл болно.

ХУУЛЬ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

Монголд зэс алт, нүүрс, төмөр, мөнгө зэрэг ашигт малтмалын ордыг гадаадын компанийн оролцоотойгоор ашиглах нөхцлийг

боловсронгуй болгох, ордын ашиглалтаас гарах ашиг хуримтлалыг Монголын талд хохиролгүй нөхцлөөр хуваарилах, хуваарилагдсан хөрөнгийг улсын эдийн засаг нийгмийн хөгжлийг хангах арга хэмжээнд зориулдаг байх талаар иргэний хөдөлгөөний зүгээс тавьж буй зүй ёсны шаардлагын дагуу ямар арга хэмжээ авахыг ард иргэд хүлээж байна. Мөн, Улсын Их Хурал, Засгийн газар байгалийн баялгийг ашиглахтай холбогдох хууль журамд дахин дахин өөрчлөлт оруулж тогтворгүй байдал үүсгэдгээ болихыг гадаад дотоодын хөрөнгө оруулагчид хүлээж байна. Эдгээр асуудлыг зохистой шийдвэрлэхэд цаг алдаж алгуурлаж болохгүй.

Улсын Их Хурал, Засгийн газрын зүгээс холбогдох хууль журмаа боловсронгуй болгох арга хэмжээ авсаар байна. Монгол улсын Ашигт малтмалын тухай хууль, Татварын тухай хуульд иргэний нийгмийн байгууллагуудын шаардлагыг харгалзан зарим өөрчлөлт оруулсан нь зүйтэй болсон. Цаашид зарчмын гэж үзэх том өөрчлөлт оруулахаас болгоомжлох хэрэгтэй.

Алив ашигт малтмалын томхон ордыг ашиглах нөхцлийн талаар гадаадын хөрөнгө оруулагчтай нэгэнт байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл нь удаан хугацаанд, хэдэн арван жилийн хугацаанд ч өөрчлөлтгүй мөрдөгдөх учраас гадаадын хөрөнгө оруулагчтай нөөц ихтэй, агуулгаар баян ашигт малтмалын ордыг ашиглах нөхцлийг ялгавартай тохирох бололцоотой

байлгах чиглэлээр ашигт малтмалын тухай хуульд /нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлэх/ өөрчлөлт оруулах шаардлага байгааг шийдэхэд цаг алдамгүй байна.

Сангийн яам, Үйлдвэр худалдааны яам, Байгаль орчны яамнаас томилсон ажлын хэсэг “Айвенхоу Майнз Монголиа” ХХК-тай Оюутолгойн зэс алтны ордыг ашиглахтай холбогдсон Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг бэлэн болгосон тухай мэдээ 2007 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр “Өдрийн сонин”-д нийтлэгджээ. Гэрээний төсөл, түүгээр ямар нөхцөл тохирч байгааг Засгийн газар, улмаар Улсын Их Хуралд оруулж хэлэлцүүлэхээс өмнө товч боловч мэдээлж байгаа нь иргэний нийгмийн төлөөллийн байгууллагууд, эдийн засагчид, эрдэмтдийн саналыг авах, ил тод байдлыг бий болгоход чиглэсэн зөв алхам юм.

Дээрх мэдээллээс үзэхэд Ажлын хэсгийн нөхөд гэрээний төслийг тохиролцохдоо:

1. Ашигт малтмалын тухай хууль болон Татварын тухай хуульд зарим өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага байгааг анхаарч санаачлага гаргасангүй.

2. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу Гэнэтийн ашгийн албан татварыг төлөхөөс “Айвенхоу Майнз Монголиа” компанийг чөлөөлөхөөр тохирох гэж байгаа бололтой. Энэ мэдээлэл үнэн бол Ажлын хэсэг эрх мэдлээ хэтрүүлж хуулийн гадуур хөнгөлөлт эдлүүлэх үйлдэл хийж байгаа хэрэг юм. Алтыг Монгол банкинд тушаахыг Зэс Алтны гэнэтийн ашгийн татвараас чөлөөлөх үндэслэл

болгох гэж байгаа бол хуулиа буруу хэрэглэсэн, хуулиас гадуур хөнгөлөлт үзүүлэх санаачлага гэж үзэж болохоор байна.

Энэ бүхэн нь холбогдох хуулийг боловсронгуй болгохгүйгээр, түүнийг хатуу баримтлахгүйгээр хөрөнгө оруулалтын гэрээг яаравчлан байгуулж болохгүй байгаагийн баталгаа.

Мэдээллийг үнэн зөв хийж байгаа эсэхэд эргэлзэхээр юм байна. “Оюутолгой төсөлд 450 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байгаа, Далд уурхайгаар 28,3 тонн зэс олборлох аж” гэж мэдээлсэн нь үнэнд нийцэхгүй байх. Ил тод байдлыг эрхэмлэж иргэдийн саналыг авах гэж байгаа бол хариуцсан асуудлынхаа тухай мэдээллийг үнэн зөв бичиж хэвлэн нийтлүүлэхийг төр засгийн албан тушаалтан нь өөрөө хариуцдаг, сэтгүүлчид найдаж орхидоггүй байвал зөв байх болно.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ БОЛОН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗАРИМ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГЫН ТАЛААР

1. Ашигт малтмалын тухай хуульд оруулах өөрчлөлт:

- **Стратегийн ач холбогдолтой гэх ордын тодорхойлолтын талаар**

“Үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсвэл жилд Монгол

улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжийн ордыг Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж үзнэ” гэж хуульд заасныг тодорхой болгох шаардлагатай.

Хуулийн энэ заалт зөвхөн ашигт малтмалын ордод хамаарах гэж ойлгож болохоор боловч дотроо зөрчилтэй, элдэв тохиолдолд янз бүрээр тайлбарлаж болохоор байна. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүн цаашид нэмэгдэх үед түүний 5 хувьд хүрэхгүй бүтээгдэхүүн гаргадаг болчихвол стратегийн ач холбогдолтой орд биш болсон гэж үзэгдэх үү?, Бүс нутгийн эдийн засаг нийгмийн хөгжилд ямар нэг хэмжээгээр нөлөө үзүүлж л байгаа бол бүх төрлийн ашигт малтмалын ордууд хэмжээнээсээ үл хамааран стратегийн ач холбогдолтойд тооцогдож байх нь зөв үү? гэх мэт асуудалд хариу олоход бэрхшээл гарна. Үндэсний аюулгүй байдал, улсын хөгжилд нөлөөлөх хэмжээтэй гэдгийг ямар критерээр тогтоох нь тодорхойгүй. Ийм асуудлуудыг тодорхой болгохгүй бол орд газрын ашиглалтад төр оролцох эсэх, оролцоо ямар хэмжээнд байх талаар хөрөнгө оруулагчидтай гэрээ хэлэлцээр хийхэд хүндрэл гарна.

Ер нь Үндэсний аюулгүй байдал, улс орны хөгжилд шийдвэрлэх нөлөөтэй үйл ажиллагааг стратегийн ач холбогдолтой гэж тодорхойлдог байвал, зөвхөн ашигт малтмалын ордын хүрээнд биш өргөн хүрээнд авч үзвэл зөв

болно. Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх стратегийн ач холбогдолтой салбар буюу үйлдвэрлэлийг тодорхойлдог, түүндээ хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зэвсэг, нисэх онгоц, сансрын техник, радиоактивын болон цөмийн материалын олборлолт, үйлдвэрлэлийг хамруулдаг, улмаар тэдгээрийн худалдаа арилжаанд оролцохыг стратегийн ач холбогдолтой үйл ажиллагаа гэж үздэг байх, харин ашигт малтмалын ордын хувьд бол нефть, байгалийн хий, алт, зэс, чулуун нүүрс гэх мэт ашигт малтмалын төрлүүдээр ордын нөөцийн хэмжээг нь харгалзаж стратегийн ач холбогдолтойд хамааруулдаг бусад улсын туршлагыг анхаарах нь зүйтэй.

ТӨРИЙН ОРОЛЦООНЫ ТАЛААР

Стратегийн ач холбогдолтой гэж үзсэн ашигт малтмалын ордыг ашиглахад төрийн оролцоо заавал байх, оролцооныхоо хувиар хөрөнгө оруулалтын зардлыг хариуцаж байхаар Ашигт малтмалын тухай хуульд заасан бөгөөд оролцооны хэмжээг хайгуулын ажлыг төр хийсэн бол 50 хүртэл, хийгээгүй бол 34 хүртэл хувь байхыг хуульчилсан. Ордын ашиглалтаас олж болох татварын дараах чөлөөт ашгийн хуваарилалтад Монголын тал ахиу хэмжээгээр оролцож байх зорилгоор төрийн оролцооны дээрх хэмжээг тогтоосон нь зөв болсон санагдана.

Оюутолгойн алт, зэсийн орд болон Тавантолгойн коксжих нүүрсний ордыг

ашиглахад гарч болох эдийн засгийн гол үзүүлэлтүүд, орлого ашгийн хэмжээг одоогийн зах зээлийн үнийн түвшинд гарган, түүний хуваарилалт ямар байж болохыг барагцаа тооцоогоор гаргаж үзлээ.

Оюутолгойн ордын ашиглалтад төрийн оролцоо 34 хувь, Тавантолгойн ордын ашиглалтад төрийн оролцоо 49 хувь байх нөхцөлд эдгээр ордын ашиглалтаас гарч болох ашиг хуримтлалын 54-70 орчим хувь нь Монголын төрд оногдон хуваарилагдах боломжийг бүрдүүлж болохоор байна. Одоогийн үнийн түвшинд дээрх харьцаагаар ашиг хуваарилагдаж байвал төрөөс эдгээр ордод оруулсан хөрөнгө оруулалтын зардлыг 1- 3 жилд нөхөх, харин ордод 51 - 66 хувийн хөрөнгө оруулсан хувийн компаниуд хөрөнгө оруулалтын зардлаа өөрт оногдох чөлөөт ашгаар 2,5-5 жилийн хугацаанд нөхөж болох байна. Зэс алтны дэлхийн зах зээлийн үнэ тооцоонд авсан хэмжээнээс доош буусан нөхцөлд хөрөнгө оруулалтын зардлыг нөхөх дээрх хугацаа уртсаж боло. Гэвч орлого ашгийн хуваарилалтын харьцаа өөрчлөгдөхгүй. Ордын ашиглалтаас гарах ашиг хуримтлалаас монголын төрд оногдох хэсгийг тооцохдоо одоогийн мөрдөж байгаа хуулийн дагуу төлөгдвөл зохих Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /роялти/, Аж ахуйн нэгжийн ашгийн татварыг ямар нэг хөнгөлөлт чөлөөлтгүйгээр төлүүлдэг байхаар, мөн Чөлөөт ашгаас 34 болон 49 хувиар оногдох орлого зэргээс бүрдэхээр бодсон.
/Тооцооны хувилбаруудыг хавсаргав./

• ***Гадаад ба дотоодын хөрөнгө оруулагчийн оролцооны талаар***

Ордын ашиглалтад төрөөс хөрөнгө оруулж оролцох хувийг хуулиар нэгэнт 34, 50 хүртэл хувь гэж тогтоосныг нэмэгдүүлэх хэрэггүй юм. Өөрөөр хэлбэл төр оролцох хувийн дээд хязгаар нь 34 буюу 49 байх нь зүйтэй. Энэ бол хувийн компанид 51- 66 хувийн оролцоо өгч, менежментийг хариуцуулах нь зүйтэй гэсэн санаа.

Монголын төр хөрөнгө оруулалтад дээд тал нь 34, 49 хувиар оролцоно гэдэг бол орд эзэмшихтэй холбогдсон эрсдлийн ихээхэн хэсгийг өөртөө хүлээж байгаа хэрэг.

Дараах зүйлийг бодолцох үндсэн дээр гадаадын хөрөнгө оруулагч компанид 51-66 хувийн оролцоотой байхыг зөвшөөрөх санал дэвшүүлж байгаа юм:

- Монгол талд ашиг хуримтлалын 54-өөс доошгүй хувь ирнэ.
- Орд ашиглалтаас гарах ихэнх бүтээгдэхүүний борлуулалт, түүнээс орох орлого, гадаад валютын эх үүсвэр нь гадаад цөөн тооны зах зээлээс хамаарахаар байдаг эрсдлээс, мөн ашигт малтмалын зүйлийн үнэ ихээхэн хэлбэлзэлтэй байдаг эрсдлээс, түүний сөрөг үр дагавраас хамгаалагдах магадлал илүү байх болно.
- Гадаадын хөрөнгө оруулагчид олон улсын хөрөнгийн зах зээлд гарцтайгаас гадна тэдний хувьцаа эзэмшигчид нь эрдэс баялгийн үнийн өөрчлөлтөөс үүсэх эрсдлийг багасгах боломж

илүүтэй, бас туршлагатай байдаг учраас тэдэнд менежментийг хариуцуулах нь зөв болно.

- Гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд зээлийн өртөг харьцангуй доогуур байх нөхцөл ашиглагддаг, бага өртөгтэй зээлийг ашиглан эрсдлийн зарим хэсгийг бусдад шилжүүлж чаддаг.

- Орд ашиглалтад гаднын компанийг арай илүү хувиар оролцуулсан нөхцөлд сайн менежмент, сайн технологи нэвтрэх боломж илүү байх болно.

- Монголын төрийн нэрийн өмнөөс томилогдсон компанид ордын ашиглалтын менежментийг хариуцуулах нь их эрсдэлтэй. Гаднын компани тийм нөхцөлд хөрөнгө оруулахаас татгалзах магадлал маш өндөр байгаа. Одоо манай улсад байгаа төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд хамгийн муу менежменттэй, тэдгээрт ашиглалт завшилт цэцгэлж байдаг, өндөр үр ашгийн төлөө ажиллах сэтгэл чадваргүй хүмүүст хөрөнгө хариуцуулах нь манайханы хэлдгээр чононд хонь хариуцуулахтай адил гэдгийг хувийн компанийхан сайн мэдэж байгаа.

Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордын ашиглалтад төр 34, 50 хүртэл хувиар оролцохын тулд орд ашиглалтын хөрөнгө оруулалтад оролцооныхоо хувьд тохирох хөрөнгө зарцуулах нь зайлшгүй бөгөөд түүний эх үүсвэрийг бүрдүүлэх аргаа олсон байх шаардлагатай. Үүний тулд орд ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг зохих стандартын хэмжээнд боловсруулж урт хугацааны бага хүүтэй зээл авах, хувьцаа гарган хөрөнгийн зах

зээлд борлуулах, болон тийм үйл ажиллагаанд оролцох зэрэг ажил зохиох хэрэгтэй болно.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ КОМПАНИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ТАЛААР

Үндэсний буюу дотоодын хөрөнгө оруулагчийг стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордыг ашиглах үйл ажиллагаа эрхлэхийг бүх талаар дэмжиж, үндэсний хөрөнгөтнийг бий болгох бодлоготой байх нь чухал юм. Ийм бодлогын үүднээс Үндэсний компани ямар нэг гаднын компанийн оролцоогүйгээр ашигт малтмалын тодорхой ордыг ашиглах үйл ажиллагаа явуулах бол түүнд төрийн оролцоог аль болохоор бага хэмжээнд тогтоож байвал зөв болно. Үүнтэй холбогдуулж ордын ашиглалтаас олж байгаа татварын дараах чөлөөт ашгийн хуваарилалтаар оногдсон орлогынхоо 50 —иас доошгүй хувийг Монголдоо ажлын байрыг нэмэгдүүлэх, тэргүүний техник технологийг нэвтрүүлсэн үйлдвэр үйлчилгээг хөгжүүлэх, экспорт нэмэх, импорт хэмнэх арга хэмжээнд зориулан ашиглах, түүнийхээ үр дүнг ил тод илтгэж байх асуудлаар стратегийн орд ашиглагч Үндэсний компани гэрээ байгуулдаг байх нь зүйтэй.

2. Татварын тухай хуульд оруулах өөрчлөлт

Стратегийн ач холбогдолтой гэж үзсэн ашиг хуримтлал ихтэй ордын ашиглалтад монголын төрийн оролцоо байлгахыг хувийн компаниуд сонирхохгүй байгаа. Гэтэл Монголын төрийн

хувьд хувь оролцох замаар монголдоо үлдэх ашиг хуримтлалыг ахиу байлгах, олборлох үйлдвэрийн ил тод байдлыг хангах, зардал орлого ашиг болон түүний хуваарилалтад хяналт тогтоож байх сонирхол байгаа. Эдгээр хоёр сонирхолыг тэнцвэржүүлэн шийдэх хамгийн боломжтой зам нь төрийн оролцоог их байлгахад биш, харин татварын хуулиа боловсронгуй болгож татвараар орох орлогыг ахиу байлгах арга олох явдал юм.

Энэ чиглэлийг баримтлан татварын тухай хуульд дараах зарим өөрчлөлтийг оруулах боломж байгаа санагддаг юм. Тухайлбал: ***Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг нэмэгдүүлэх.*** Энэ нь орлого ашгаас Монголд үлдэх хэмжээг найдвартай нэмэгдүүлэх бөгөөд ордын олборлолтод төрийн оролцоог илүү байлгах эрсдэл ихтэй алхмаас ухралт хийх бололцоо өгнө.

Ашигт малтмалын тухай хуульд “Дотоодод борлуулж байгаа нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр түүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү байх”-аар заасныг өөрчилж “Дотоод , гадаад зах зээлд борлуулж байгаа нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр түүний борлуулалтын үнэлгээний 5 хувьтай тэнцүү байх” гэж өөрчлөх, “Дээр зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан

бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5 хувьтай тэнцүү байна” гэснийг 7-7,5 хувьтай тэнцүү байна гэж өөрчлөхөд их эсэргүүцэлтэй тулахгүй болов уу.

Ашигт малтмалын нөөц ашигласны татварын хэмжээг ингэж өөрчилсөн нөхцөлд бусад улсад байдаг татварын дундажаас их гарахгүй. ***Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулийг цаашид тууштай баримтлах хэрэгтэй.*** Тухайлбал, Унци алтны суурь үнийг 500 ам доллар, тонн зэсийн суурь үнийг 2600 ам доллараар тогтоон түүнээс давсан үнийн дүнгээс 68 хувийн татвар оногдуулдаг болсныг өөрчлөхгүй дагаж мөрдөх нь чухал. Бусад улсад байдаг зүйл.

Ашигт малтмалын ордыг монголд ашиггүй, харин хохиролтой нөхцөлөөр ашиглуулж, гадаадын компанид хэт их ашиг хонжоо олгож байхыг эсэргүүцэж, иргэний нийгмийн зүгээс тавьж буй зүй ёсны шаардлагыг анхаарч ***Монгол улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийг 2006 оны 6 дугаар сард өөрчилж, гадаадын хөрөнгө оруулагчдад олон жилээр татвар төлөхгүй байх буюу их хэмжээний хөнгөлөлт авч байсныг хүчингүй болгосон нь зөв болсон. Нэгэнт татварын дарамтыг бага болгосон учраас дотоод ба гадаадын хөрөнгө оруулагчдад адил нөхцөл бүрдүүлж өгсөн нь зохистой шийдвэр болсон бөгөөд цаашид татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг гаргахгүй байх нь чухал.***

Ашигт малтмалын тухай болон татварын тухай хуульд оруулж болох өөрчлөлтийн талаар, мөн дэлхийн нилээд улсууд олборлох салбарын ил тод байдлын санаачлага хэрэгжүүлж байгааг монголдоо нэвтрүүлэх талаар гаргаж байгаа дээрх саналууд ойлгогдож дэмжигдэн шийдэгдвэл Монгол улсын байгалийн баялгийг улс ард түмний ашиг сонирхолд нийцүүлж ашиглах, гадаадын хөрөнгө оруулагчдыг үргээх биш шударга нөхцөлөөр сонирхуулан оролцуулахад тус болох нь дамжиггүй.

СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛТОЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН АШИГЛАЛТААС ТӨРД ОРЖ ИРЭХ АШИГ ХУРИМТЛААЛЫН ХУВААРИЛААЛТ АШИГЛАЛТЫН ТАЛААР

Монголын иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчдийн зүгээс ашигт малтмалын ордын ашиглалттай холбогдсон санал шаардлагын гол зорилго нь ашигт малтмалын ордуудыг монгол улсад хохиролтой биш ашигтай нөхцөлөөр ашиглах, түүнд гадаадын хөрөнгө оруулагчдыг сонирхуулан оролцуулах нөхцөл хангасан хууль зүйн орчин бүрдүүлж хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангаж ашиглах завших явдал гаргахгүй байхад оршиж байгаа.

Орлого ашгийг төр ба хувийн компанийн хооронд шударга зарчмаар ил тод аргаар хуваарилдаг болгох, төрд орж ирсэн орлого ашгийг хэрхэн зарцуулсны хариуцлагыг засгийн газар нь иргэдийнхээ өмнө хүлээдэг байхыг шаардаж байгаа болохоос биш бэлэн

орд буюу бэлэн мөнгө хувааж өгдөг болохыг шаардаад байгаа юм биш гэж би ойлгодог.

Иргэдийн зүгээс тавьж буй энэ шаардлагыг хэрхэн оновчтой шийдэх аргыг олох санаачлагаар өрсөлдөх биш, /алаагүй баавгайн арьсыг хуваах гэгчээр/ орд газрыг үнэлж хувьцаа нэрээр тараах, эсвэл ирээдүйн ашгийг эх орны хишиг нэрээр мөнгөөр хуваан өгч байх мэтгэлцээн явагдаж байх шиг санагдана. Хувьцаа хишиг тарааж байх саналууд оновчтой биш, хэрэгжүүлье гэж бодоход улс нийгмийн хөгжилд эерэг биш сөрөг нөлөө үзүүлэх байх. Энэ талаар манай эдийн засагчид санал бодлоо тодорхой илэрхийлэхгүй байна. Улс төрийн нам, төрийн удирдах нөхдөөс гаргаж байгаа саналд болгоомжтой хандаж байгаа нь ойлгомжтой. Энэ хариуцлагатай асуудлаар хүмүүс өөрийн саналыг нуулгүй болгоомжлохгүй хэлэх ёстой. Миний бодлоор бол Тавантолгойн нүүрсний ордын нөөцийг үнэлж хувьцаа гэж бүх иргэдэд тараасан нөхцөлд уг ордыг ашиглах асуудлыг эдийн засгийн хувьд утга учиргүй болгоно, ашигт малтмалын орд ашиглалтын чөлөөт ашгийн төрд оногдох хэсгийг хишиг нэрээр иргэдэд тарааж өгдөг болчих бол бэлэнчлэх сэтгэлгээ гэж нэрлээд байсан ажил хийхгүй амьдраад байх хэвшлийг бий болгоно гэж би болгоомжлоод байгаа юм.

Энэ асуудлаар Дэлхийн Банкны төлөөлөгчөөс саналыг нь сонссоныг сониноос харлаа. Тэр

хүн бэлэн мөнгө тараах хувилбар байж болох. Тэгэхдээ хөгжлийн зорилгод нөлөөлөх арга замыг олох нь чухал гээд Латин Америкийн зарим улсад хүүхдүүдийг сургуульд бүрэн хамруулах, иргэдийн эрүүлийг хамгаалах зорилгод маш үр дүнтэйгээр мөнгө зарцуулсан байдаг гэж хэлжээ. Энэ хүн хөдөлмөрийг үнэлсэн биш мөнгө тараахыг буруу, улс нийгмийн хөгжилд нөлөөлөх арга хэмжээнд хөрөнгө зарвал зохино гэдгийг болгоомжтойгоор, тэхдээ тодорхой хэлсэн байна билээ. Мөнгө баялаг тарааж өгөх сайхан саналыг эсэргүүцлээ гэх хүн гарах учраас болгоомжилсон маягаар хэлжээ гэж би ойлгосон.

МӨНГӨНИЙ ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРТ ГАРЧ БОЛОХ ӨӨРЧЛӨЛТ

Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын томхон ордыг ашиглах хөрөнгө оруулалтын зардлын мөнгөний бодит үнийг ирээдүйд хүлээх мөнгөн урсгалын үнэлгээтэй харьцуулан тооцох, өөрөөр хэлбэл мөнгөний худалдан авах чадварын өөрчлөлтийг тооцож үзэх шаардлагатай. Үүнийг хөрөнгө оруулах төрийн өмчийн газар болон хувийн хөрөнгө оруулагч компани анхаарах байх.

Миний хувьд мөнгөний худалдан авах чадварын өөрчлөлтийн тооцоог хийх онцын шаардлагагүй, түүнээс нийт үр ашгийн тооцоонд онц нөлөөлөх зүйл гарахгүй болов уу гэж бодогдсон. Ордыг ашиглах төслийг боловсруулж хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн

төслийн хүч чадлыг бүрэн эзэмшихэд бага хугацаа зарцуулахыг хөрөнгө оруулагчид эрхэмлэн хэрэгжүүлэх бололцоо байгаа. Ийм учраас ашиг хуримтлал, түүний хуваарилалтын тооцоог жил жилээр биш, төслийн хүч чадал бүрэн ашиглагдаж байх жилийн хэмжээнд хийсэн юм. Энэ нь ордын ашиглалт дахь төрийн болон хувийн өмчийн хөрөнгө оруулагчдын оролцоо, ашиг хуримтлалын хуваарилалтын оновчтой харьцаа ямар байх асуудлаар зарчмын шийдэлд хүрэхэд хангалттай өгөгдөхүүн болно гэж бодсон болно.

АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫГ АШИГЛАХ ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ БА БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

1. Зэс, алт, нүүрс зэрэг ашигт малтмалын орд, түүний нөөц дахин сэргээгдэхгүй. Хөрөнгө оруулагчид, ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчид ашигт малтмалын ордын нөөцийг, зах зээл л байвал, аль болох их хэмжээгээр олборлож түүхий эдийн хэлбэрээр борлуулж, богино хугацаанд ашиг олохыг сонирхоно. Үүнийг тэдний зүгээс харвал буруутгаж болохгүй. Гэвч хөрөнгө оруулагчдын сонирхол Монгол улсын төр засгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн бодлогод дандаа зохицохгүй.

Богино хугацаанд ашиг олох сонирхолд хөтлөгдөж эдгээр ашигт малтмалын ордын нөөцийг цөөн жилийн хугацаанд олборлож дуусгахаас болгоомжлох, эдийн засгийн хувьд

ашигтай байх олборлолтын зохистой хэмжээг тооцон тогтоож ордын нөөцийг аль болох олон жил ашиглах бодлого хэрэгжүүлэх нь Монгол төрийн чухал бодлого байх ёстой.

Алив ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлах, ордыг ашиглахад шаардагдах дэд бүтцийг бүрдүүлэх ажилд Засгийн газар шийдвэрлэх үүрэгтэй оролцох замаар дээрх бодлогоо хэрэгжүүлэх боломж байгаа. Ашигт малтмалынхаа нөөцийн зохих хэсгийг ирээдүй - хойч үеэ бодож үлдээх, улсын болон бүс нутгийн хөгжил, дэд бүтцийн ашиглалт, хот суурингийн иргэдийн ажил эрхлэлт амьдралын ирээдүйг харсан бодлого хэрэгжүүлж байх нь Монголын төр засгийн үүрэг.

2. Ашигт малтмалыг түүхий эд хэлбэрээр экспортлохыг аль болохоор хязгаарлаж, боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортолдог болох бодлого хэрэгжүүлэх нь чухал. Жишээлбэл:

- Зэс олборлох 3 үйлдвэртэй болох ирээдүй байна. Эрдэнэт, Оюутолгой, Цагаансуваргын зэсийн ордыг ашиглах уулын баяжуулах үйлдвэрүүдээс жилд 500-600 орчим мянган цэвэр зэс агуулсан баяжмал үйлдвэрлэгдэх бөгөөд тэдгээрийг тал талаас тээвэрлэн хүргэх төмөр замын тээврийг бий болгох замаар Чойр орчимд зэс хайлуулах үйлдвэр байгуулах төлөвлөгөөтэй, тэр нь үндэсний хөгжлийн хөтөлбөрт цогцоор тусч хэрэгжих ёстой. Чойр орчимд ийм үйлдвэр баригдвал бүтээгдэхүүнийг нь Ази болон Европын зах

зээлд борлуулах нөхцөлтэй байна. Өөрөөр хэлбэл, Оюутолгой ба Цагаансуваргын ордын ашиглалтаас гарах зэсийг баяжмал хэлбэрээр нэг хоёр зах зээлд борлуулдаг бол зах зээлийг өргөтгөх боломжтой болно

Харин цэвэр зэсийг ямар бүтээгдэхүүн болгож боловсруулбал борлуулалтын ирээдүйтэй байхыг тусгайлан судалж шийдвэл зохино. Хаанаас ч худалдан авч болдог янз бүрийн зэс утас үйлдвэрлэх биш харин хэрэгцээний ирээдүй их байж болох нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг эрхэм зорилт болгон хэрэгжүүлбэл зүйтэй. ХҮ-ийн сайдаар ажиллаж байсан Жаргалсайхан өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамын зэс утас үйлдвэрлэх нь ирээдүйтэй гэж үзэж байсан нь зөв санагддаг юм. Энэ бол нэг л бүтээгдэхүүний жишээ.

- Монгол улсад коксжих, чулуун болон хүрэн нүүрсний нөөц багагүй байна. Дэлхийн хэмжээнд нүүрсний ирээдүйн хэрэгцээ багасахгүй. Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлтэд ашиглагдаж байгаа Байгалийн хий болон газрын тосны нөөц 50-60 жилд хүрэлцэнэ, түүнийг орлох гол түлш нь нүүрс байх бөгөөд, нүүрсний нөөц хэдэн зуун жилийн хэрэгцээнд хүрэлцэнэ гэж тооцдог байна.

Манай улсын хувьд нүүрсний ордуудаа ашиглахад бодлоготой хандах хэрэгтэй. Нүүрсийг боловсруулахгүйгээр зөвхөн түлшинд хэрэглэх нь үр ашгийн хувьд

төдийгүй байгаль орчинд үзүүлэх нөлөөний хувьд сөрөг үр дагавар ихтэй гэж үзэж байгааг анхаарах ёстой. Кокс, хагас кокс үйлдвэрлэх, нүүрсийг гүнзгий боловсруулж хий, нефть орлох бүтээгдэхүүн гаргаж авах талаар гадаад орнуудад хийгдэж байгаа туршилт судалгааг идэвхтэй судлан, тэргүүний гэж үзэх технологи техникийг авч нэвтрүүлэх нь чухал зорилт байвал зүйтэй. Нүүрсийг боловсруулах замаар нефть бүтээгдэхүүнийхээ /500 орчим мянган тоннын/ хэрэгцээг өөрийн эх үүсвэрээс хангаж, импортын хамаарлыг багасгах боломж байж болох юм. Энэ бол бодлогын чанартай асуудал.

АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ҮНЭ ОРЛОГЫГ ХЯНАХ АСУУДАЛ

Манай Засгийн газар 2007 оны 4 дүгээр сард Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг жишиж үнэлэх, түүнийхээ аргачлалыг тогтоох тухай шийдвэр гаргасан байна.

Засгийн газар, ашигт малтмалын орд ашиглаж, бүтээгдэхүүнээ экспортод гаргаж байгаа компани борлуулалтын орлогоо багасган мэдээлж, төсөвт татвар бүрэн төлөхөөс зайлсхийхтэй тэмцэх гол зорилгоор дээрх шийдвэрийг гаргасан байх. Энэ шийдвэрт тусгасан арга зөв эсэхэд эргэлзэж байна.

Алт, зэс, цайр, хар цагаан тугалга зэрэг үнэт болон өнгөт металлын борлуулсан байвал

зохих үнийг Лондонгийн металлын бирж дээр зарласан үнийн дундажаас үндэслэж тооцдог байх нь зөв бөгөөд боломжтой.

Нүүрс, төмрийн хүдэр, жонш зэрэг бүтээгдэхүүний борлуулах үнэ гэж металлын биржээр зарлагддаггүй. Учир нь, эдгээр бүтээгдэхүүн их хэмжээгээр арилжаалагддаг, худалдагч худалдан авагчид нь эрэлт нийлүүлэлтийн нөхцөл, тээврийн зай зардлыг харгалзан үнийг маш их зөрүүтэйгээр тохиролцож болдог учраас биржээр жишиг гэж болох үнийг зарлах нөхцөл үндэслэл байдаггүй. Ийм учраас манайх ямар нэг улсын сэтгүүлд нийтлэгдсэн үнэ, мөн зарим улсын хоорондын худалдааны гэрээгээр тохирсон үнийг нүүрс, төмрийн хүдэр, жоншийг экспортлоход баримтлах ёстой үнийн жишиг болгоно гэсэн шийдвэр гаргахаар төлөвлөж, санал авч байгаа нь буруу юм.

Ямар нэг улсын дотоодын үйлдвэрлэлийн тухай мэдээлэлд хэвлэгдсэн үнийн тухай мэдээ нь тухайн улсын үйлдвэрлэгч болон худалдан авагч нар хэрэглэгч нийлүүлэгчдийн байршил, зах зээлийн эрэлт хангалт зэрэг ямар нөхцөлийг харгалзан тохиролцсон үнэ болохыг харуулахгүй. Манай экспортолж байгаа бүтээгдэхүүн ямар зайд тээвэрлэгдэж ямар нөхцөлөөр гадаадын худалдан авагчид нийлүүлэгдэж байхыг зэрэгцүүлж судлахгүйгээр дээрх мэдээлэлд нийтлэгдсэн үнийг жишиг үнэ гэгч болгон хэрэглэх гэх нь наанадаж гадаад худалдаанд үнэ

тохиролцдог арга практикийн мэдлэггүй хүний санаачлагаар засгийн газрын шийдвэр гарчээ гэсэн дүгнэлтэд хүргэж болно. Хэрэв ашигт малтмалын орд ашигладаг компани бүтээгдэхүүн экспортлох асуудлаар гаднын компанитай хэлэлцээр хийх үедээ “ худалдан авагч компанитай үнэ тохиролцох хэлэлцээрт биднийг төлөөлөн оролцож, тогтоосон жишиг үнийхээ түвшинд үнэ тохиролцож өгнө үү” гэсэн хүсэлт гаргавал холбогдох төрийн байгууллагын ажилтан яаж хандах вэ? гэсэн асуудал аяндаа гарч байгаа юм.

Ер нь Төрийн зүгээс нүүрс, эрчим хүчний үнийг чөлөөлөх алхам хийхгүй удаж байгаа бол одоо экспортын бүтээгдэхүүний үнийг төр тогтоох, төрийн өмч давамгайлсан байдал бий болгох алхам хийж байгаа нь ажиглагдаж байна. Шинэ үндсэн хуулийн үзэл санааны дагуу зах зээлийн эдийн засагт шилжих, үүнтэй холбоотойгоор үнэ чөлөөлөх зарчмын чиглэлээсээ ухрав гэсэн шүүмжлэлд өртөх биш биз.

Уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортод ашигтай үнээр борлуулах, борлуулсан бодит үнэд орлого ашиг хуримтлалыг тодорхойлж, нөөц ашигласны төлбөр болон татварын орлогыг улсын төсөвт бүрэн хуримтлуулах зорилгоор ажиллах нь зүйтэй.

Харин ийм зөв зорилтыг төрөөс үнэ тогтоож байх буруу аргаар хэрэгжүүлж боломгүй. Үүний оронд дараах аргаар ажиллах нь зүйтэй санагдана:

- Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түүний ирээдүй, тэргүүний технологи, зах зээл үнийн талаарх мэдээллийг энэ салбарт үйлдвэрлэл эрхэлж байгаа үндэсний компаниудад тогтмол хүргэж байхын зэрэгцээ тэдэнд тэргүүний технологи олж нэвтрүүлэх, зах зээлд өрсөлдөх чадвартай байхад нь төрийн зүгээс дэмжлэг үзүүлдэг байх,

- Оновчтой зах зээл, худалдан авагчийг зөв сонгох, экспортлох бүтээгдэхүүний үнийг ашигтай нөхцөлөөр тохирход нь үндэсний компанид төр засгийн байгууллагын зүгээс зөвлөгөө өгч тусалдаг байх,

- Нэг төрлийн үйлдвэрлэл эрхэлж байгаа Монголын компаниудыг аль болохоор корпораци болгон нэгтгэх, бодлого үйл ажиллагааг нь нягт уялдуулдаг болгох арга хэмжээ авах,

- Экспортлох бүтээгдэхүүний үнэ, орлогыг зөв мэдээлж байгаа эсэхийг хянах хэрэгтэй. Үүний тулд үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжийн удирдлагын бүрэлдүүнд төрийн төлөөллийн хүнийг оролцуулах, төрийн хөрөнгийн оролцоог зарим хэмжээгээр байлгах, санхүү мөнгөний урсгалд нь тавих хяналтыг боловсронгуй болгох зэрэг ажлыг зохиож болно. Энэ ажилд ОСИТБС –ын шугамаар идэвхтэй ажиллах, иргэний нийгмийн байгууллагын хяналтыг зохион байгуулах боломж байгаа.

*Судалгаа хийж, дүгнэлт санал боловсруулсан
Думаагийн Содном
2007 оны 5 дугаар сар*

АШИГТ МАЛТМАЛЫН СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛТОЙ ГЭЖ ҮЗЭЖ БҮЙ АЛТ ЗЭС, КОКСЖИХ НҮҮРСНИЙ ЗАРИМ ОРДЫН АШИГЛАЛТААС ОРЖ БОЛОХ АШИГ ХУРИМТЛАЛ БОЛОН ТҮҮНИЙ ХУВААРИЛАЛТАД ХЭРЭГЛЭХ НӨХЦЛҮҮДЭЭР ХИЙСЭН БАРИМЖАА ТООЦОО, ТҮҮНЭЭС ХИЙЖ БОЛОХ ДҮГНЭЛТ САНАЛ

НЭГ. ОЮУТОЛГОЙН ЗЭС АЛТНЫ ОРДЫН ЖИШЭЭН ДЭЭР ХИЙСЭН БАРИМЖАА ТООЦОО

Энэ тооцоонд ашгийн татварыг 25 хувиар авсан. Нэмэгдэл өртгийн болон экспортын татвар тусгаагүй. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 5 хувиар өртөгт тусгагдсан гэж тооцсон болно.

1. Оюутолгойн зэс алтны ордын нөөц:

Зэс	16 сая тонн
Алт	362 тонн

Энэ нөөц 30 сая тонн зэс, 100 тонн алт болж нэмэгдэх мэдээлэл бий

2. Ордыг ашиглахад шаардагдах хөрөнгө оруулалтын зардал:

2 400 000 000 ам доллар

3. Олборлолтын жилийн хэмжээ:

Зэс	400 000 тонн цэвэр зэс
Алт	9 200 кг /буюу 296 680 унци/

4. Жилийн борлуулалтын орлого:

Айвенхоугийн тооцоонд авсан үнээр	Зах зээлийн үнээр
- Зэс а/400 000х 2220- 888 сая долл.	6/ 400 000х 5000-2000 сая долл
- Алт а/ 296 680х 400- 118,7 сая долл.	6/ 296 680х 500-148,3 сая долл
Бүгд 1 006,7 сая долл	2 148,3 сая долл

5. Жилийн олборлолтын бүх өртөг / Барагцаа / 432 000 000 ам доллар

6. Татварын өмнөх ашиг

Айвенхоугийн тооцоонд авсан үнээр	Зах зээлийн үнээр
574,7 сая долл :	1716,3 сая долл

7. Ашгийн татвар 25%

Айвенхоугийн тооцоонд авсан үнээр	Зах зээлийн үнээр
143,7 сая долл:	429,1 сая долл

8. Татварын дараах ашиг

Айвенхоугийн тооцоонд авсан үнээр	Зах зээлийн үнээр
431,0 сая долл	1 287,2 сая долл

9. Хөрөнгө оруулалт нөхөх хугацаа

Айвенхоугийн тооцоонд авсан үнээр	Зах зээлийн үнээр
5,6 жил	2 жил

10. Чөлөөт ашиг хуваарилагдах хэмжээ:

Айвенхоугийн тооцоонд: авсан үнээр	Зах зээлийн үнээр
Татварын дараах ашгийн хуваарилалт:	
34 хувь Монголд 146,5 сая долл	437,6 сая долл
66 хувь Компанид 284,5 сая долл	849,6 сая долл

Нийт ашиг хуримтлалын хуваарилалт:

	Монгол талд		Айвенхоу компанид	
	Шинэ үнийн	Хуучин үнийн	Шинэ үнийн	Хуучин үнийн
1. Нөөцийн төлбөр ба ашгийн татвараар	194,0 сая	536,5 сая	-	-
2. Чөлөөт ашгийн хуваарилалтаар /431сая . 1287,2 сая./ Төрийн 34 %-ийн оролцооны нөхцөлд	146,5	437,6	284,5	849,6
Бүх ашиг хуримтлал хоёр талд хуваарилагдах хэмжээ:				
Бүгд / А /	340,5	974,1	284,5	849,6
Харьцаа	54,0 %		46,0 %	
Тус тусын хөрөнгө оруулалтын зардлаа нөхөх хугацаа	2,4 жил	0,8 жил	5,6жил	1,9 жил

11. Нөөц ашигласны төлбөр

Айвенхоугийн тооцоонд: авсан үнээр	Зах зээлийн үнээр
50,3 сая долл	107,4 сая долл

12. Ашгийн татвар

Айвенхоугийн тооцоонд: авсан үнээр	Зах зээлийн үнээр
143,7 сая долл	429,1 сая долл
Нийлбэр нь	
194,0 сая долл:	536,5 сая долл

Дүгнэлт, санал

1. Ашигт малтмалын ордын ашиглалтад Монголын төрийн өмчийн газар буюу Монголын үндэсний компани хувьцааны нь 34 хувийг эзэмшиж, менежментийг гадаадын компанид хариуцуулан хяналт сайн тавьж ажиллах нөхцөлд нийт ашиг хуримтлалын 54 орчим хувь нь Монголд үлдэж, 46 хувь нь гадаадын компанид оногдох юм байна.

Зэс алтны одоогийн үнийн түвшингээр хийсэн дээрх тооцооноос үзэхэд 34, 66 хувийн оролцооны нөхцөлд Монголын тал хөрөнгө оруулалтынхаа 1 доллар тутамд 1,2 долларын ашиг хуримтлал авах бол Айвенхоу компани 54 центийн ашиг авах байна. Дэлхийн банкны судалснаар Оюутолгойтой адил төстэй уурхайн бизнесээс гадаадын хөрөнгө оруулагчид гол төлөв 15-20 хувийн ашиг хүртэх хүлээлттэй байдаг гэсэн. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтаа 5-6,5 жилд нөхөх ашиг оногдож байвал хангалттай гэж үздэг байна. Гэтэл дээрх тооцоогоор Айвенхоу компани өөрийн 66 хувийн хөрөнгө оруулалтаа одоогийн зах зээлийн үнийн нөхцөлд 2 жилийн хугацаанд нөхөх бололцоотой нь харагдаж байна. Энэ бол хэт өндөр ашгийн нөхцөлтэйгөөр ордын ашиглалтад оролцоно гэсэн үг. Ийм учраас:

А. Айвенхоу компанид татварын хөнгөлөлт үзүүлэх нь ямар ч утгагүй юм.

Б. Аж ахуйн нэгжийн ашиг орлогын татварыг нэмж болохгүй учраас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр / роялти /

-ийг нэмэгдүүлэх хууль гаргах нь зүйтэй байна. Нүүрсний нөөц ашигласны татварыг түүнийг экспортод гаргасан нөхцөлд оногдуулдаг болох, түүнээс бусад ашигт малтмалын нөөцийг ашигласны татвар 5 хувь байгааг 7-7,5 хувь болгоход их эсэргүүцэл гарахгүй.

В. Монгол улсын УИХ-аас 2006-5-12 –ны өдөр гаргасан Үнийн өсөлтийн албан татварын хуулийг тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй. Алтны унцийн үнэ 500, Зэсийн тоннын үнэ 2600 ам доллараас давсан хэсгээс 68 хувийн татвар авч байх нөхцөлд Монгол талд оногдох ашиг хуримтлал дээр дурьдсан 54 хувиас илүү байх болно.

Г. Зэсийн баяжмалд экспортын татвар оногдуулах боломжийг судалж шийдэх шаардлагатай байж болох. Айвенхоу компанитай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хэлэлцээрийг эцэслэн шийдэхээс өмнө татварын болон ашигт малтмалын тухай хуульд дээр санал болгосны дагуу өөрчлөлт оруулж, тэр үндсэн дээр тохиролцоо хийх нь зүйтэй.

2. Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордыг Монголын үндэсний компани эзэмшин ашиглах бол түүнд төрийн өмчийн газрыг заавал оролцуулахгүй байх, оролцуулсан нөхцөлд 34 хувиас илүүгүй байлгах, харин тэрхүү ордынхоо ашиглалтад гадаадын компанийг оролцуулахыг хүсвэл 51 хүртэл хувиар оролцуулахыг Үндэсний компанид зөвшөөрдөг байх хууль гаргавал зохимжтой.

Ийм хууль гаргахдаа Үндэсний компанийн стратегийн ордын ашиглалтаас олсон чөлөөт

ашгийг гадаадад байршуулахыг хязгаарлах, гадагш гуйвуулбал татвар оногдуулдаг байх, харин эх орондоо ажлын байр шинээр бий болгох, шилдэг техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх хөрөнгө оруулалтад зориулан ашиглахыг урамшуулж байх заалтыг тусгах нь зүйтэй болно.

3. Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордын ашиглалтад Монголын төрийн оролцох хэмжээг 50 –иас дээш хувь байлгах талаар Ашигт малтмалын тухай 2006 оны 7 сарын 8-ны өдрийн хуульд өөрчлөлт оруулах гэвэл гадаадын хөрөнгө оруулагчид дургүйцэж, хөрөнгө оруулахаас татгазах үр дагавартайг бодолцох хэрэгтэй. Төр 34 хувиар оролцох нөхцөлд бүх ашиг хуримтлалын 54, түүнээс дээш хувь нь Монгол талд оногдох бололцоо байгаа учраас төрийн оролцоог Ашигт малтмалын тухай хуулиар нэгэнт тогтоогоод байгаа хэмжээнээс нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн менежментийг төрд авах асуудал тавих нь их эрсдэлтэй болохыг онцолж анхаарахгүй бол болохгүй.

ХОЁР. ТАВАНТОЛГОЙН НҮҮРСНИЙ ОРДЫН ЖИШЭЭН ДЭЭР ХИЙСЭН БАРИМЖАА ТООЦОО

Энэ тооцоонд ашгийн татварыг 25 хувиар авсан. Нэмэгдэл өртгийн болон экспортын татвар тусгаагүй. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг борлуулалтын дүнгээс 2,5 хувиар тооцсон. Нүүрсийг экспортолсон нөхцөлд нөөц ашигласны төлбөр

оногдуулахгүй байх хуультай боловч тэр хуульд өөрчлөлт оруулж төлбөр авдаг болох нь зүйтэй гэсэн үндсэн дээр тооцоонд авсан.

1. Нүүрсний жилийн олборлолт 20 сая тонн

Үүнээс борлуулах бүтээгдэхүүн:

- Коксжих нүүрсний баяжмал 8 сая/тон
- Эрчим хүчний чулуун нүүрс 11 сая/тон

2. Ордын ашиглалтын хөрөнгө оруулалт:

4 тэрбум ам доллар.

3. Бүтээгдэхүүнийг борлуулах үнэ:

- Коксжих нүүрсний баяжмал 100доллар/тон
- Эрчим хүчний нүүрс 50 доллар/тон

4. Борлуулалтын орлого:

- Коксжих нүүрсний баяжмал 800 сая ам доллар.
- Эрчим хүчний нүүрс 550 сая ам доллар.

Дүн 1 350 сая ам доллар.

5. Өртөг: 230 сая ам доллар

- Коксжих нүүрсний баяжмал 15дол/тон 120 сая
- Эрчим хүчний нүүрс 10 дол/тон 110 сая

6. Нөөц ашигласны төлбөр /2,5%/

33,7 сая ам доллар

7. Ашиг /1350-230- 34/

1 086 сая ам доллар.

8. Ашгийн татвар /25%/

272 сая

9. Цэвэр ашиг: /1086-272/

814 сая

10. Хөрөнгө оруулалтын нөхөлт

5 жил

11. Ашиг хуримтлалын хуваарилалт

Төрийн оролцооны хувь:	51 хувь	49 хувь
А/ Төрд орох бүх ашиг үүнээс	721 сая	705 сая
- нөөц ашигласны төлбөрөөр	34 сая	34 сая
- ашгийн татвараар	272 сая	272 сая
- чөлөөт ашгаар /814/	415 сая	399 сая
Хуримтлалд эзлэх хувь /1120/	64 хувь	63 хувь
Б/ Компанид оногдох ашиг		
- чөлөөт ашгаар /814/	399 сая	415 сая
Хуримтлалд эзлэх хувь /1120/	36 хувь	37 хувь
Хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа:		
- төрийн хувьд	/2000 сая : 721 сая/	3 жил
- компанийн хувьд	/2000 сая : 399 сая/	5 жил

Дүгнэлт санал

1. Тавантолгойн нүүрсний ордыг ашигласнаар гарч болох 1 120 сая ам долларын ашиг хуримтлалаас 63 хувь нь төрийн мэдэлд хуваарилагдах боломжтой учраас уг ордын ашиглалтад төрийн оролцоог 49 хувиас илүүгүй тогтоож, менежментийг хувийн компанид хариуцуулах нь зөв байж болох.

2. Энэ ордыг ашиглах компанид татварын ямар нэг хөнгөлөлт үзүүлэх нь утгагүй. Харин хүсэлт гаргавал ордын ашиглалтын эхний жилүүдэд оногдсон ашгийн татварыг төлөх хугацааг хойшлуулж болохыг хуульдаа анхаар болох юм.

3. Ордын ашиглалтад оролцох үндэсний компанитай чөлөөт ашгаа Монголд ажлын

байр нэмэх, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлэх, нийгмийн асуудлыг шийдэхэд зориулах талаар тохиролцоо хийсэн байвал зүйтэй.

4. Энэ ордын хайгуул ашиглалтын зөвшөөрөл Монголын үндэсний компаниудын нэгдэлд олгогдоод байгаа нь зүйтэй байна. Хэрэв Үндэсний компани нь ордын ашиглалтад сайн менежмент, тэргүүний техник технологи нэвтрүүлэн ашиглах, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлэхэд дэмжлэг олох зорилгоор зарим гадаадын компанийг өөрийнхөө оролцооны хэмжээнд оролцуулахыг сонирхвол зөвшөөрөх, тэгэхдээ гаднын компанийн оролцоог 49 хувиас хэтрүүлэхгүй байхыг зөвлөх нь зүйтэй.

**ОЮУТОЛГОЙН ЗЭС АЛТНЫ ОРДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ,
АШИГ ХУРИМТЛАЛ, ТҮҮНИЙ ХУВААРИЛАЛТЫН БАРИМЖАА ТООЦОО,
ТҮҮНЭЭС ХИЙХ ДҮГНЭЛТ, САНАЛ**

Үнийн өсөлтийн татвар болон ашгийн татварыг авах, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг борлуулалтын орлогоос 5 хувиар төлүүлж байхаар энэ тооцоог хийсэн. Нэмэгдэл өртгийн болон экспортын татвар тусгаагүй.

1. Оюутолгойн ордын тооцоонд авсан нөөц:

- Зэс 16 сая тонн; - Алт 362 тонн.

2. Ордыг ашиглахад шаардагдах хөрөнгө

оруулалтын зардал:

2 400 000 000 ам доллар

3. Олборлолтын жилийн хэмжээ:

- Зэс 400 000 тонн.

- Алт 9200 кг буюу 296 680 унци.

4. Борлуулалтын орлого:

- Зэс 400 000 тон 5 000 ам дол/ тн
2 000 000 000 ам долл

- Алт 296 680 унци 500 ам дол/ унци
148 300 000 ам долл
Бүгд 2 148 300 000 ам долл

5. Үнийн өсөлтийн татвар

/5000-2600= 2400 дол./

/400 000X 2400= 960 000 000/

/960 000 000X 68 хувь/ 652 800 000 ам долл

6. Үнийн өсөлтийн татвар хассан борлуулалтын орлого

1 496 300 000 ам долл

7. Бүтээгдэхүүний өртөг 432 000 000 ам долл

8. Татварын өмнөх ашиг 1 064 000 000 ам долл

**9. Аж ахуйн нэгжийн ашгийн татвар /25 %/
266 000 000 ам долл**

10. Татварын дараах ашиг 798 300 000 ам долл

Ашиг хуримтлалын хуваарилалт	Монгол талд	Компанийн талд
1. Хөрөнгө оруулалт / ам дол/	816 000 000	1 584 000 000
2. Оролцооны хувь	34	66
3. Ашиг хуримтлалын хувиарлалт:		
- Нөөц ашигласны төлбөрөөр	107 400 000	-
- Аж ахуйн нэгжийн ашгийн татвараар	266 000 000	-
- Татварын дараах ашгийн хуваарилалтаар	271 400 000	526 900 000
Бүгд	644 800 000	526 900 000
А/ Хувийн жин	55%	45 %
Үнийн өсөлтийн татварыг бодолцвол	1 296 800 000	526 900 000
Б/ Хувийн жин	71 %	29%
Компанид оногдох чөлөөт ашгийг гадагш гүйвуулахад 5 хувийн татвар авах нөхцөлд /526,9X5= 26,3 сая/	1 323 100 000	500 600 000
В/ Хувийн жин	72,5%	27,5 %
4. Хөрөнгө оруулалтын зардлыг нөхөх хугацаа /жил/	0,6 – 1,3	3 – 3,2

Дүгнэлт, санал

1. Ашиг хуримтлалын хуваарилалт нь монгол талд харьцангуй ашигтай бөгөөд гадаадын компанийн Монголд хөрөнгө оруулах ашиг сонирхолыг хадгалах боломжтой байна. Татварын хөнгөлөлт 2006 оны хуулиар нэгэнт үгүй болсон учраас Монголд хөрөнгө оруулахаа болино гэх тохиолдол их гарахгүй гэж үзэж байна. Оюутолгой мэт өндөр үр ашиг өгөх төслийг хэрэгжүүлэхээс татварын асуудлаас болж татгалзана гэж бодохгүй байх нь зөв.

2. Ашигт малтмалын тухай хуулиар Төрийн оролцоог 34 хүртэл, 50 хүртэл хувь байхаар тогтоосныг нэмэгдүүлэх, ялангуяа 50 ба

түүнээс дээш болгох саналд гаднын болон үндэсний компаниуд дургүйцэл илэрхийлж байгаа. Ашгийн ихэнх хувийг хүртэж байх сонирхол тэдэнд байгаа нь тодорхой. Гэвч үйлдвэрлэлийн менежментийг монголын төрийн компанид авах нь маш их эрсдэлтэй. Нөгөө талаар төрийн оролцоог нэмэх нөхцөлд монголын төрийн зүгээс хөрөнгө оруулалтын эх үүсвэр олох асуудал улам хүндрэлтэй болно. Ийм учраас Төрийн оролцооны хувийг хуулиар тогтоосон хэмжээнээс нэмэгдүүлэх хэрэггүй гэж үзэж байна. Харин үүний оронд Ашигт малтмал ашигласны төлбөрийг зарим хэмжээгээр нэмэгдүүлбэл ирээдүйтэй, илүү үр дүнтэй байх болно.

“АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫГ ҮР АШИГТАЙ АШИГЛАХ АСУУДАЛД” САНАЛ ЗӨВЛӨМЖИЙН ГОЛ АГУУЛГА

Ашигт малтмалын орд ашиглах зөвшөөрлийг хөрөнгө оруулагчдад олгох нөхцөл, орд ашиглалтын ашиг хуримтлалыг бодитоор мэдээлэх, зохистой ашиглах асуудалд иргэд, улс төрчид, эдийн засагчдын анхаарал төвлөрч байна.

Хөрөнгө оруулагчтай ашигт малтмалын ордыг ашиглахад оролцуулах талаар байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл удаан хугацаанд мөрдөгдөнө. Ийм учраас юуны өмнө ашигт малтмалын ордыг ашиглах ямар тодорхой нөхцөлүүд Монгол улсын ашиг сонирхолд хохирол учруулахгүй байх, нөгөө талаас хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолыг бодолцсон байхыг зохистой шийдэхэд онц анхаарч, алгуурлахгүй байх шаардлагатай.

Санал зөвлөмжид дараах үндсэн асуудал тусгагдсан:

- Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу тооцвол ордын ашиглалтаас олох ашиг хуримтлал Монголын төрд болон Хөрөнгө оруулагчид ямар харьцаагаар хуваарилагдах магадлалтайг Оюутолгойн алт зэс, Тавантолгойн коксжих нүүрсний ордын жишээн дээр баримжаа тооцоогоор гаргаж санал дэвшүүлсэн.

- Ордын ашиглалтад төрийн оролцоо байх хэмжээг тогтоосон хууль, Үнийн өсөлтийн татварын тухай хуулийг өөрчлөлтгүй дагаж мөрдөх шаардлага үндэслэлийг хэлсэн.

- Ашигт малтмалын тухай болон Татварын тухай хуульд өөрчлөлт оруулж болох зарим заалт ба түүний үндэслэлийг гаргасан.

- Ордын ашиглалтаас төрд төвлөрөх ашиг хуримтлалын зориулалт, мөн уул уурхайн бүтээгдэхүүнд жишиг үнэ тогтоох асуудлаар санал бичиж үндэслэл гаргасан.

- Боловсруулах үйлдвэртэй болох, Үндэсний компанийг дэмжих бодлоготой байх, мөн ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГА-д нэгдэн хэрэгжүүлэхийн ач холбогдлыг үндэслэсэн болно.

Нийгмийн анхаарал төвлөрч байгаа энэ чухал асуудлаар дэвш үүлж буй санал зөвлөмийг анхааралтай хэлэлцэн зохистой шийдвэр гаргаж хэрэгжүүлбэл Нөөц баялгийн ашиглалтаас орох орлогын удирдлагыг сайжруулах, Эдийн засаг улс төрийн тогтвортой байдлыг бий болгох, Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, Алив зөрчилөөс сэргийлэх зэрэг олон талын ач холбогдол үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Төр засгийн удирдлага, миний санал дүгнэлтүүдийг анхааралтай судлан, шаардлагатай гэж үзвэл иргэний нийгмийг төлөөлж байгаа нөхдийг оролцуулан ажил хэрэгчээр шүүн хэлэлцээд бүрэн ойлголтоор тууштай шийдвэр гаргаасай гэж хүсч байгаа болно.

Санал зөвлөмж бичсэн Д.Содном 2007.05.10

“МОНГОЛ УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫГ ҮР АШИГТАЙ АШИГЛАХ АСУУДАЛД” ЛЕКЦИЙН ТЭМДЭГЛЭЛ

Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор Д.Содномын “Монгол Улсын ашигт малтмалын ордыг үр ашигтай ашиглах асуудалд” лекц 2007 оны тавдугаар сарын 29-нд ННФ-ын хурлын танхимд боллоо. Лекцийн эхэнд ННФ-ын гүйцэтгэх захирал Б.Эрдэнэжаргал үг хэлж, лекцийн дараа оролцогчид санал хүсэлтээ хэлж, илтгэгчид асуулт тавилаа.

Ц.Дамиран /УИХ-ын гишүүн/

Олон нийтийн болон төр засгийн анхаарлын төвд буй хоёр том орд дээр харьцуулсан судалгаа хийж өөрийн санал бодлоо илэрхийлж байгаа Д.Содном гуайд талархаж байна.

Монгол Улсын Засгийн газар “Айвенхоу Майнз” компанитай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулаад УИХ-аас баталчихвал ажил нь хурдан явах байх. Харин Тавантолгойн орд дээр 4 тэрбум төгрөгийг босгох ямар арга байна вэ? Засгийн газраас тодорхой хэмжээний бондыг олон улсын хөрөнгийн зах зээл дээр гаргах, эсвэл, тодорхой хувийг нь компаниудад зараад мөнгө босгох талаар та ямар бодолтой байна? Хэдэн хоногийн өмнө Австралийн “ВНВ” гэдэг том компанийн төлөөлөл УИХ-ын гишүүдтэй уулзсан. Тавантолгойн ордыг маш их сонирхож байсан. Тодорхой хувьд нь оролцож, хөрөнгө гаргая гэж байгаа. Мөн

Америкийн “Пибоди” компанийхан гурван сарын өмнө УИХ-ын гишүүдтэй уулзаж санал бодлоо илэрхийлсэн. Дэлхийд тэргүүлдэг их том компани юм билээ. Мөн л Тавантолгойн ордыг сонирхож хөрөнгө оруулж хамтран ажиллах бодолтойгоо илэрхийлээд байгаа.

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр олно гэдэг түвэгтэй нь ойлгомжтой. Би 34 хувиар авч үзээд Оюутолгойн орд дээр 800 орчим сая доллар гэж тооцсон байгаа. Хэрвээ тэр хөрөнгийг гаргачихвал Оюутолгойн ордоос авах төрд ногдох ашгаараа нэг жилийн дотор бараг нөхчихөөр харагдаж байгаа юм. Энэ эх үүсвэрийг яаж олох вэ. Юуны өмнө олон улсын стандартыг хангахуйц хэмжээнд төслөө боловсруулсан байвал түүнийг санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээл өгье гэсэн олон улсын банк болон олон улсын байгууллага хангалттай байгаа юм биш үү. Өөрөөр хэлбэл, зээл авах нэг арга нь энэ байх болов уу.

Хоёрдугаар арга бол “Айвенхоу Майнз”-ын жишээгээр хувьцаа гаргаж түүнийгээ зарах хэрэгтэй. Энэ компани чинь бидний нэрээр хувьцаа гаргаж мөнгө босгоод байдаг. Гэтэл бид уг ордын эзэн нь байдаг. Бидэнд огт хамаагүй юм шиг суугаад байх нь зөв үү, буруу

юу. Энэ орд дээр хувьцаа гарган борлуулж мөнгө босгож байгаа бол тухайн мөнгөний тодорхой хэмжээ нь Монголын төр оногдох ёстой гэдгийг ашиглалтын гэрээндээ тусгаж болохгүй юм уу гэсэн санаа байна. Та нар үүнийг анхааралдаа авах хэрэгтэй байх аа.

Тавантолгойн ордод дөрвөн тэрбум төгрөг үнэхээр их тоо. Гэхдээ ашгийг нь хараа биз дээ. Нэгэнт ийм их ашигтай байгаа учраас эх үүсвэрийг олж авахад айх хэрэггүй. Улсын хэмжээгээр нэг миллиард 300 саяын зээл авчихсан байгаа биз дээ. Зарим зээлийг ямар эх үүсвэрээр төлөх нь тодорхой биш. Засгийн газар зээлийг эргүүлэн төлөх талаар бүх зээлдэгч байгууллагатай тодорхой гэрээ хийж чадаагүй. Маш их рисктэй зээл аваад л байгаа шүү дээ. Харин тодорхой орд дээр зээл авна гэдэг бол риск багатай. Техник, эдийн засгийн үндэслэлийг нь сайн боловсруулсан л бол зээлийг өгч чадна. Одоогийн зах зээлийн үнээр авахад хоёр жилийн дотор нөхөж болохоор байна. Ийм богино хугацаанд хөрөнгө оруулалтаа

нөхөх ашигтай зүйл дээр зээл авахад болгоомжлох хэрэггүй гэж бодож байна.

С.Авирмэд

Та 2006 оны хууль дээр үндэслэж тооцоогоо хийжээ. Энэ хуулиар 34 хүртэл хувь гэж заасан байгаа. Улсын төсвөөр бол 50 хүртэл хувь гэж заасан. Та дээд хэмжээгээр нь хийчихэж. Та энэ үндэслэлийн талаар юу гэж бодож байна вэ? Яагаад заавал 34 хувь, 50 хувь байдаг юм бэ. Тэгээд төр өөрийнхөө өмчийг худалдаж авдаг энэ зарчим зөв үү? Үндсэн хуультай харшилж байгаа юм биш биз.

Ашигт малтмалын хайгуулыг төрийн өмчөөр хийсэн, хувийн өмчөөр хийсэн гэж ялгагдаж зарчмыг та эдийн засагчийн хувьд хүлээн зөвшөөрч байна уу? “Айвенхоу Майнз”-д 200 гаруй тэрбум долларын үнэт баялаг байгаа. Тэдний өсгөснөөр зардал нь 400 сая. Энэ нь нэг хувь ч хүрэхгүй шүү дээ. Ийм зөрүү байхад нэг нь 51, нэг нь 34 хувь гээд байгаа. Эрдэнэтээс 120 мянган тонн зэс, Оюутолгойн



ордоос 16 сая тонн хүдэр олборлож 400 сая тонн зэс гарна гэж та тооцоолжээ. Би 400 мянган тонн зэс гэж ойлголоо. Эсвэл баяжмал байсан юм уу. Үүнд тооцооны алдаа байгаа юм биш үү.

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Одоо нэгэнт хууль гарчихсан учраас 34 хүртэл хувь, 50 хүртэл хувь гэж ямар үндэслэлтэй тогтоосныг би тайлбарлаж мэдэхгүй байна. 34 болон 50 хүртэл хувийг оновчтой зөв болжээ гэж үзэж байгаа. 34 хувь хүртэл гэхээр 34 хүргээд зогсоно, 50 хүртэл хувь гэдгийг 49 гэж ч ойлгож болно. Нэг хувийг нааш цааш болгож болох л байх. Ямар ч гэсэн энэ хуулиар менежмент, рисковийг хөрөнгө оруулагчдад нь хариуцуулж өгчээ. Ингэснээрээ их оновчтой болжээ. Үүнийг 50 болон түүнээс дээш болгоно гэж ярьж байгаа бол утгагүй яриа.

Монголын төр яагаад өөрийнхөө хөрөнгийг худалдаж авч байгаа юм бэ гэлээ. Манайд ашигтай ашигт малтмалын орд байна. Энд ямар нэгэн хөрөнгө оруулахгүй бол ашигт малтмал чинь хэвтэж л байна шүү дээ. Хөрөнгө оруулж, хөдөлмөр зарцуулж байж л жинхэнэ үнэт баялаг болж таарна. Худалдаж авч байгаа юм биш. Харин түүнийгээ ашиглахад төр ямар хэмжээнд оролцож, хэдий хэмжээний хөрөнгө оруулах вэ гэдгийг л тодорхойлох гэж байгаа юм. Хэрвээ манайд тийм хөрөнгийн бололцоо байсан бол, энэ техник технологийг эзэмшсэн боловсон хүчний нөөцтэй бол бид 100 хувь ашиглахад

огт асуудал байхгүй. Тийм потенциалтай орнууд ч гадны хөрөнгө оруулалтыг оролцуулдаг нь жам юм байна лээ. Тэгэхээр өөрийн хөрөнгөө худалдаж авна гэдэг нь буруу ойлголт болов уу.

Эрдэнэтэд 120 мянган тонн зэс олборлож байгаа. Оюутолгойн орд дээр 400 мянган тонн зэс олборлоно гэдгийг би түрүүн хэлсэн. 400 мянган тонн гэдэг өөрчлөгдөж болох тоо. Жилд олборлох баяжмалд агуулагдсан зэсийн хэмжээг 400 мянган тонн гэж би тооцсон юм. Үүнийг нэмж ч болно, хасч ч болно. Эцэст нь ашиг хуримтлалын хуваарилалтын хувийн жин дээр өөрчлөлт гарахгүй. Тэр хадгалагдана. Харин нийт ашгийн хэмжээнд нөлөөлөх зүйл бий.

Д.Байлхүү /ТӨХ/

Хүмүүс хувьцаа гаргаж хөрөнгө босгоод түүгээрээ юм хийчихье гэж яриад байгаа. Тийм арга байж болно л доо. Өнөөдөр 34 хүртэл хувь, 51 хүртэл хувь гээд тогтоочихсон учраас хэрвээ хувьцаа гаргаж худалдвал манай хувьцаа гаргасан хэмжээгээрээ буурна гэдгийг мартаад байх шиг. Өөрөөр хэлбэл, хувьцаа гаргаж хөрөнгө олох явдал нэлээн хязгаарлагдмал болов уу. 51 хувь, 34 хувиа авчихаад хөрөнгө оруулагчийг хувьцаа гаргаж түүгээрээ үйлдвэрээ байгуул гэвэл дэндүү шударга бус болно байх. Тэгэхээр хөрөнгө оруулалтын өөр л бодлого баймаар санагдаж байна. Үүнийг та юу гэж бодож байна вэ?

Эцсийн бүтээгдэхүүн, боловсруулах үйлдвэрийн тухай ярьж байна. Түүнийг

ямар түвшинд ярьж байна вэ? Зэсийн хувьд эцсийн бүтээгдэхүүнийг борлуулах, эцсийн бүтээгдэхүүний зах зээлийг авч явах гэдэг нэлээн түвэгтэй юм шиг санагддаг. Жишээ нь, зэсээр хийсэн эдлэл байна. Сайхан юм хийчихэж болох байх. Гэхдээ түүнийг эргүүлээд зах дээр худалдахад амаргүй юм шиг. Манай ордуудыг дэлхийн томоохон компаниуд үнэхээр сонирхож байна. Энэ чиглэлээр ажилладаг дэлхийн номер нэг компаниуд бүгд л Монголд ирлээ. Бид нэгдүгээр сарын сүүлчээр цуглуулахад 10 гаруй компани ирсэн. Тэдний дотор дэлхийн толгойд явдаг нь ч ирсэн. Энэ сонирхол дундаас Хятад улсыг ямар түвшинд оролцоосой гэж та бодож байна? Ямар бодлого барих нь зүйтэй гэж боддог вэ?

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/
Хувьцааны талаарх миний мэдлэг маруухан. 34 хувь, 51 хувь хүртэл гэж төрөөс өөрт ногдох хөрөнгө оруулах хэмжээг тогтоочихлоо шүү дээ. Өөрийнхөө энэ хэмжээнд хувьцаа гаргаж борлуулаад мөнгө олох бололцоо байгаа болов уу. Өөрөөр хэлбэл, 34 хүртэл хувь дотроо зарим хэсгийг нь хувьцаа болгоно гэсэн үг. Үүнийг бодох л хэрэгтэй. Хэрвээ 34 хувиасаа заримыг нь хувьцаа болгож борлуулчихвал ногдох ашиг нь тэр хэмжээгээрээ багасна шүү дээ. Үүнийгээ бас бодох хэрэгтэй.

Эцсийн бүтээгдэхүүн гэдэг дээр тантай санал нэг байна. Эцсийн бүтээгдэхүүн гэдэг нь ганцхан абсолют зорилготой байж

болохгүй гэж би түрүүн хэлсэн. Өнөөдөр зэсийн баяжмал байвал булаацалдаад авч магадгүй. Хайлуулсан зэс гаргачхаад ав гэхээр хэцүү байж мэднэ. Харин үүнээс цаашаа явах хэрэгтэй байна. Зах зээл дээрээс янз бүрийн хэмжээтэй зэс утсыг хаанаас ч авахад хүндрэлгүй байх. Ийм бүтээгдэхүүнд нэг их зах зээл олдохгүй байх.

Надад нэг хүн ярьж байсан. Одоогийн цахилгаан дамжуулах өндөр хүчдлийн шугамууд голоороо нэг ган утастай, гадуураа 5-6 хөнгөн цагаан утастай байгаа. Нэг 220-ын шугам барихад нэг хөл дээгүүр 4-5 шугам явдаг. Ийм шугамаар явахад цахилгаан 20 хувь хүртэл хаягддаг гэж байсан. Хэрвээ өндөр хүчдэлийн энэ шугамын утсыг нь зэсээр хийвэл нэгээс хоёрхон Жи-гээр /G/ явна. Харин цахилгааны хаягдал хоёр хувиас хэтэрдэггүй гэсэн. Бид ийм л зүйлийг бодох хэрэгтэй байх. Ямар бүтээгдэхүүн ямар ирээдүйтэй байна, ямар технологийг ашиглах вэ гэдгийг эцсийн бүтээгдэхүүн дээр бодох ёстой. Хайлуулах үйлдвэрийг барих явцад юм уу, эсвэл, техник эдийн засгийн үндэслэлээ боловсруулах үед энэ судалгаагаа хийсэн байх ёстой гэж бодож байгаа. Өөрөөр хэлбэл, эцсийн бүтээгдэхүүний хувьд бодлого байх хэрэгтэй.

Хятад улс яаж оролцох вэ гэлээ. Ийм төслийн санал ирсэн байхыг би үзсэн. Өмнөговийн Гашуунсухайтаар орж Оюутолгой, Тавантолгойгоор дайраад, зүүн тийшээ Нарийнсухайтаар эргэж, Шивээхүрэнгийн

боомтоор буцааж гаргах 700-800 км нарийн төмөр замыг барья, энэ нь танай уурхайнуудыг ашиглах тээврийн асуудлыг шийдэхэд их хэрэгтэй, хөрөнгө оруулалтыг нь бид өөрсдөө гаргая гэсэн төсөл гурван жилийн өмнө ирчихсэн байгаа. Мэдээж түүхий эдийг авах л бодлого байгаа шүү дээ. Энэ бодлогын эсрэг өөрийнхөө бодлогыг зөв гаргах ёстой. Тийм учраас түүхий эдээ гаргахгүйгээр, аль аль тал руу гарч байх нөхцлөө бодож дэд бүтцээ ч байгуулах хэрэгтэй, үйлдвэрлэлээ ч байгуулах хэрэгтэй. Гэхдээ Хятадыг оролцуулахгүй гэсэн бодлого байж болохгүй ээ. Тэр том зах зээлийг бид ашиглах л хэрэгтэй. Гэхдээ өөрийн бодлоготой, өөрийн сонирхлоо хадгалах ёстой гэж бодож байна.

С.Болд /ҮХЯ-ны ажилтан/

Өнөөгийн зах зээлийн үнэ ханшийн байдал болоод ордын нөөц, хүчин чадал дээр үндэслэгдэж хийгдсэн иймэрхүү баримжаа тоон дээр хийсэн дүгнэлт үндэс муутай байх талтай. Төрийн оролцоо төдий хэмжээтэй байх ёстой, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төдийн хооронд хэлбэлзэх ёстой гэсэн дүгнэлтүүд ч учир дутагдалтай. Тухайн ордуудын техник, эдийн засгийн үндэслэл болон гадаад зах зээл дэх бүтээгдэхүүний үнэ ханшийн урт хугацааны загварууд дээр үндэслэгдсэн мөнгөн урсгалын аргачлал, бодит офшиний аргачлалаар төслийн үнэлгээг гүйцэтгээд, түүн дээрээ үндэслэж өгөөж нь ямар байх юм бэ, төрийн оролцооны хувь хэд байх вэ, татвар хураамжийн хувь хэд байх вэ гэсэн загвар тооцоо гарч ирдэг юм. Тэгэхээр ингэж

нарийвчилж хийж тодорхой загвар боловсруулсны үндсэн дээр төрийн оролцооны хувь 34 байх, татвар хэд байх гэдэг нь тодорхой болох юм.

Эцсийн бүтээгдэхүүний зах зээлийн талаар сая ярилаа. Баяжмал юунд хэрэглэгддэг вэ гэдгийг аваад үзье. Баяжмал гэсэн шороог хүн хэрэглэхгүй шүү дээ. Түүнийг хайлж цэвэршүүлээд эцсийн бүтээгдэхүүнийг хийж байгаа. Эцсийн бүтээгдэхүүний хэрэгцээ байгаа тохиолдолд баяжмалын хэрэгцээ байна. Өнөөдөр баяжмал үйлдвэрлэхихээд зах зээл нь сайн байна, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхихвэл зах зээл нь олдохгүй гэсэн маш буруу ойлголт явж байгааг энд үгүйсгэмээр байна.

Хөрөнгө босгох тухай, хувьцааны тухай яригдаж байна. “Айвенхоу Майнз” компанитай Монголын Засгийн газар хамтарсан үйлдвэр хэлбэрээр ажилласан тохиолдолд тэрхүү хамтарсан үйлдвэрийн хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээл дээр гаргах асуудал яригдана. Харин хамтарсан үйлдвэр байгуулаагүй тохиолдолд энэ бол хаалттай сэдэв юм. “Айвенхоу Майнз” компанийн хувьцаа, хамтарсан үйлдвэрийн хувьцаа гэдэг хоёр зүйлийг ялгаж ойлгох хэрэгтэй байна. “Айвенхоу Майнз” компанийн хувьцаа одоо Монголд ямар ч хамаагүй байгаа. Харин Монголын Засгийн газраас тодорхой хэмжээний хөрөнгө оруулж /34 юм уу, 51 ч юм уу/ тэр ордыг ашиглах хамтарсан үйлдвэрлэл байгуулаад түүнийхээ хувьцааг олон улсын зах

зээл дээр гаргая гэвэл шийдвэрлэж болох нэг арга зам нь санхүүгийн зуучлалын байгууллага буюу хөгжлийн банк гэсэн статустай байгууллага байх ёстой.

Дэлхийн аж үйлдвэрлэлийг хөгжүүлсэн туршлага нь Ази, Латин Америк, Америкийн бүс, Африк, Европын орнуудад гадаадын зээлээр биш, санхүүгийн зуучлалын байгууллага буюу хөгжлийн банктай холбоотой байдаг юм. Дэлхийн арав гаруй орны хөгжлийн банкны хууль, дүрэм журмыг судалж үзэхэд Монгол Улсад хөгжлийн банк үнэхээр шаардлагатай болсон байна. Яагаад гэвэл Тавантолгойн орд, Оюутолгойн ордод Монголын талаас оруулж байгаа хөрөнгө, Монголын талыг төлөөлж байгаа компани нь дэлхийн хөрөнгийн зах зээл дээр хувьцаа гаргах эрх байхгүй. Чадахгүй. Үүнийг хэн гаргах вэ гэвэл хөгжлийн банк гаргана. Хөгжлийн банкны кредит рейтинг нь олон улсын байгууллагуудаар тогтоогдсон байдаг. Энэ зээлийн үнэлгээний үндсэн дээр олон улсын хөрөнгийн зах зээл дээр хувьцаа арилжигдах эрх нь нээгдэх юм. Хувьцааны санхүүжилтын хувьд ийм байна. Хөгжлийн банкны хоёрдахь үүрэг бол тухайн орныхоо нутаг дэвсгэр дээрх аж үйлдвэрийг хөгжүүлэхэд урт хугацаатай, маш уян хатан нөхцөлтэй, маш бага хүүтэй ашгийн төлөө бус зээлийн үйлчилгээг үзүүлнэ.

Өнөөдөр зарим хүмүүс арилжааны банкуудаар дамжуулж энэ ордуудыг чинь санхүүжүүлж

болдоггүй юм уу гэдэг. Нэгдүгээрт, Монголын арилжааны банкуудад ийм чадавх байхгүй. Хөрөнгийн чадавхийн багтаамжийн хувьд шүү дээ. Хоёрдугаарт, зээлийн хүү ийм өндөр байгаа нөхцөлд аж үйлдвэр хэзээ ч хөгжихгүй. Гуравдугаарт, арилжааны банкууд ашгийн төлөө, эзэмшигчийн төлөө байгууллагууд гэдгийг санах хэрэгтэй. Тэгвэл хөгжлийн банк бол ашгийн төлөө бус, ашгийн төлөө гэхээсээ аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын төлөө байгууллага юм. Тэгэхээр хөгжлийн банкны тухай, эцсийн бүтээгдэхүүний зах зээл, төслийн үнэлгээ явуулах аргачлалын асуудлыг цааш нь сайн судалж үзээсэй гэж хүсэх байна.

Дорждарь /ННФ-ын менежер/

Та Оюутолгой, Тавантолгой тухай ярилаа. Хөрөнгө оруулалтын гэрээг манайд хийж байгаа. Энэ гэрээний хэвлэл дээр гарсан зарим танилцуулгад гэнэтийн ашгийн татварыг авахаа больсон харагдаж байсан. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэл эхэлснээс хойш таван жилийн дотор ямар ч татвар авахгүй гэсэн үг. Таван жилийн дотор “Айвенхоу Майнз” компани боловсруулах үйлдвэр барьчихвал татварыг бүрмөсөн авахгүй, хэрвээ барихгүй бол татвараа буцаагаад авна гэж байгаа. Боловсруулах үйлдвэр барихад ямар өртөг гардаг юм бол. Таван жилийн гэнэтийн ашгийн татвараараа тэр үйлдвэрээ бид барьчих юм биш байгаа гэсэн бодол байна.

Миний ойлгосноор татварын орчныг тогтворжуулдаг нөхцөл гэрээнд ордог юм

байна. Жишээ нь, хөрөнгө оруулагч гэрээ байгуулчихлаа, татварын орчин хөрөнгө оруулагчийн хувьд таатай байна. Өөрөөр хэлбэл, татварын хувь хэмжээ буурах зэрэг нөхцөл нь таатай бол хөрөнгө оруулагчид үүнийг эдлэх боломжийг олгочихдог. Хэрвээ таагүй нөхцөл буюу татварын хувь хэмжээ нэмэгдэхэд хөрөнгө оруулагчид үүнийг үүрэхгүй байх нөхцлөөр татварын орчинг тогтворжуулах нь зөв юм уу, буруу юм уу?

Хөгжлийн банкны тухай сая ярьж байна. Энэ тал дээр бас бодолцох зүйл бий байх. Хөгжлийн банк бол чөлөөт зах зээлд тодорхой хэмжээгээр оролцож байгаа нэг хэлбэр. Улсын банк яаж ажилладгийг Хадгаламжийн банкны жишээ сайн харуулсан байгаа. Мөн Хөгжлийн банкны ихэнх хөрөнгө оруулалт нь дотоод руу чиглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, манай эдийн засагт дотоод руу чиглэх тэр их хөрөнгийг шингээх чадвар бий юу. Гадаад зах зээл рүү гарч гадаадын компаниудад хөрөнгө оруулж ажиллах ёстой биш үү.

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Үнийн өсөлтийн 68 хувийн татварын тухай хууль над их таалагддаг хууль. Манай компаниуд, ялангуяа алт олборлож буй компаниуд их л дургүйцэж байдаг юм. Тэр ч аргагүй. Тэднийхний зүгээс харвал зөв. Ер нь улсынхаа зүгээс авч үзвэл тэр дэлхийн зах зээлийн үнэ дээшээ өсч байгаад манай уул уурхайн компаниудын өөрийн гавьяа

зүтгэл гэх зүйл байхгүй. Орж ирж буй тэр их ашгийг төр ахиухан авчихъя гэх нь зөв л болов уу. Ялангуяа дээрх хоёр ордтой хөрөнгө оруулалтын гэрээг цаашид байгуулахад 68 хувийн татвараа авч байхаар гэрээгээ хийх нь зүйтэй гэдэг дээр би хатуу зогсч байгаа. Татварын орчинг тогтвортой байлгана гэдэг нь зөв байх аа. Хөрөнгө оруулагч нар ийм татвар төлнө гэж орж ирчихээд нэг үйлдвэр барьж байтал юм уу, 3-4 жилийн дараа татварыг нь хамаагүй нэмчихвэл тэд чинь дургүйцнэ шүү дээ. Гэрээ байгуулна гээд зүтгэж байгааг буруутгах аргагүй. Гэрээ байгуулах нь зүйтэй. Тогтвортой орчныг бүрдүүлж өгөх нь зүйтэй. Харин үүнээс өмнө татварын хуульд боловсронгуй болгох зүйл байвал түргэхэн шиг шийдчихмээр байгаа юм. Нөөц ашигласны төлбөр 5 хувь чинь арай багадаж байгаа биш биз. Үүнийг 7.5 хувь хүргэхэд болохгүй зүйлгүй. Иймэрхүү жаахан нэмчихмээр зүйл байвал одоо л хийх хэрэгтэй. Тэгээд дараа нь төр төдөн хувь оролцоно гэж байснаас татвар хэлбэрээр үүнийг авах нь зовлонгүй, механизм нь ч зөв болмоор санагдаад байгаа юм.

П.Эрдэнэжаргал /ННФ-ын Гүйцэтгэх захирал/
Сая нэг ийм санаа гарлаа. Хэрвээ татвар буурвал компаниуд буурсан хэмжээгээрээ татвараа төлнө. Харин нэмчихвэл тэр орчин тогтвортой байна гэдэг зөв үү гэж.

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/
Нэгэнт гэрээ хийчихвэл буурч байсан, өсч

байсан ямар ч нөхцөлд адил, гэрээндээ туссан байдлаараа явна гэж би ойлгож байгаа. Буурвал буурна, өсвөл өснө шүү гэж хийхгүй байх.

Боловсруулах үйлдвэр дээр болгоомжтой хандана гэдэг нь зөв юм. Нэг юм гаргаад тавьчихдаг, нөгөөдөх нь борлогдохгүй байж болохгүй. Ямар ч хэрэггүй бүтээгдэхүүн болно. Австралид коксжих нүүрс ихтэй юм гэсэн. Бүх нүүрсээ коксжуулж борлуулдаггүй, одоо татгалзаж байгаа гэсэн. Яагаад гэвэл металлургийн янз бүрийн үйлдвэрүүд коксны чанарт нь янз бүрийн шаардлага тавьдаг гэнэ. Өөрөөр хэлбэл, хэрэглэгч нарт тэр бүрт тааруулж коксоо үйлдвэрлэнэ гэдэг их зовлонтой. Нэг стандартаар коксоо хийчихлээр зарим кокс нь борлодоггүй. Тийм учраас ийм бодлого барьж байгаа гэж сонссон. Түүнээс үлгэр авч боловсруулах салбарт бодлогоо зөв чиглэлд чиглүүлэх нь маш зүйтэй юм. Гэхдээ ямар технологиор, ямар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх вэ гэдгээ маш сайн бодож хийх нь зөв.

Хөгжлийн банкнаас зээл авна гэдэг зүйтэй л гэж бодож байна. Сая Европын Сэргээн босголтын банк маш их хөнгөлөлттэй, аятайхан нөхцлөөр зээл өгөх асуудлыг шийдчихлээ гэж Баяртсайхан сайд яриад байна лээ. Ийм сайхан төсөл байна, үүнийг санхүүжүүлэх зээл өгөөч гэхэд болох байх л даа. Монголын арилжааны банкнаас ийм хөрөнгө оруулалт босгоно гэдэг бол одоохондоо болохгүй гэдэг санаа зөв. Тийм чадалтай банк ч байхгүй. Том хөрөнгө оруулалтын нөхцөл нь ч хэцүү.

Д.Бямбасүрэн /Ерөнхий сайд асан/

Боловсруулах үйлдвэрийн тухай яригдаж байна. Миний бодлоор бодлогын асуудал дээр стратегийн нэг том зорилт байх ёстой. Юу гэвэл их хэмжээний хүдрийн баялаг ойр зэргэлдээ зах зээлд борлуулагдана шүү дээ. Тухайлбал, хоёр талын их гүрэнд. Монгол орон их гүрнээ түүхий эдийн дагуул болгохгүй гэсэн нэг бодлого төрд байх ёстой.

Хоёрдахь бодлого бол эдийн засгийн асуудал юм. Эрдэнэт үйлдвэр дээр ярья. Дэлхийн жишгээр бодож үзвэл зэсийн үйлдвэрүүд дээр хүдрийг газраас ухаж авахаас эхлээд катодын зэс гаргах хүртэлх бүх зардлын 70 хувь нь баяжуулах шат хүртлээ гардаг. Ашгийн 70 хувь нь нөгөө баяжмалаа хайлуулсны дараа гарч ирдэг. Эрдэнэтийн зэс бол зөвхөн зэс биш. Энэ дээр шинжилгээ хийлгэж үзэж байсан. Наяад оны эхээр нэг тонн зэсийн баяжмал дотор 4 грамм алт гардаг байлаа. 4 грамм алтны агууламжтай хүдэр гэж юу байдаг билээ. Та бүхэн бодоод үзэх биз. Эрдэнэтийн зэсийг хайлуулахад жилд 60 тонн мөнгө гардаг юм. 1991 онд Засгийн газрын хэлэлцээр хийхдээ мөнгөнийхөө талыг Монгол орон буцааж авъя гэдэг саналыг би тавьж тухайн үед хэдэн тонныг буцаан авч байсан санагдах юм. Түүнд бас селен, делур байгаа. Өнгөт металлын баяжмал гэдэг бол дандаа комплекс байдаг. Зөвхөн зэсийн баяжмал гаргаад авдаг юм биш. Эдийн засгийн үр ашгийг нь тооцож хамгийн оновчтой хувилбарыг нь олох тухай Содном гуай ярьж байна. Түүнийг л шийдэх хэрэгтэй.

Гэхдээ түүхий эдээ хавсарга болгох асуудлыг үргэлж бодох ёстой юм. Энэ илтгэлд дэвшүүлж буй саналуудыг хүлээж аваад анхаарвал олон юм багтсан байгаа. Манай зарим хуульд доголдолтой зүйлүүд бий. Одоогийн Ашигт малтмалын тухай хууль, Татварын тухай хууль бол модон хууль гэж би боддог. Зэсийн үнэ 2600-аас дээш гарна гэж хэн бодлоо, алтны үнэ 500 доллараас дээш гарна гэж хэн ч бодлоо. Зардлын төдөн хувиас илүү ашиг олсон нөхцөлд ашгийн төдөн хувийг нь авна гэсэн хууль байвал уян хууль болно. Манайхан ингэж ярихаар 68 хувь, төдөн доллараас дээш тохиолдолд гэдэг. Дэлхий дээр долларын нөөц асар их болжээ. Долларын ханш 1975 оныхтой адил унавал яах вэ. Арав дахин унасан шүү дээ.

Сая нэг хэлэлцээ хийж байна гэнэ. Татвараас таван жил чөлөөлнө гээд. Тэр залуу зөв хэллээ. Чөлөөлсөн татвар нь зэс хайлуулах үйлдвэр барих зардлаас хоёр дахин давчих гээд байна шүү дээ. Манай төрийн хүмүүс юу бодож суудаг юм. Ийм хэлэлцээ хийж байгаа нөхцөлд бас бэрхшээлтэй.

Энэ илтгэл дотроос гурван зүйлийг их гол гэж би үзэж байна. Нэгдүгээрт, цаашид ашигт малтмалаа боловсруулж гаргах асуудлыг оновчтойгоор шийдэх, хоёрдугаарт, уул уурхай, ашигт малтмалын үйлдвэрийг Монголын экологийн сүйрлийн цахиур болгочихгүй байх юм. Экологийн асуудлыг маш нарийн тооцож ярилгүйгээр хөрөнгө оруулах юм бол аюултай. Өмнөговьд хонины ходоод харлачихаад байна

гэдэг бол нэг л дохио. Дарханы Хонгор сум, Хөвсгөлийг хар. Алтныхан Бугантын голыг улаанаар эргүүлчихээд байхад манай байгаль орчныхон хаана байна. Манайд төр байхгүй. Энэ бол их үнэтэй зүйл шүү. Гуравдугаарт, гадны компаниудтай гэрээ хийхдээ онгорхой нүх үлдээх биш, тэнд ажиллаж байгаа хүмүүсийн ахуй амьдрал, нийгмийн асуудлыг шийдэх талаар цогц байдлаар тусгах ёстой. Ашиг авахын тулд нэг гэрээ хийж орд газраа өгчихөж болно л доо. Тэгээд хэдэн доллар аваад ийш тийш нь үрээд, хувааж идээд л дуусна. Манайхны яриад байгаа хишиг хүртээнэ гэдэг нь зөв ч юм уу, буруу ч юм уу. Миний бодлоор ашгаараа зэсийнхээ боловсруулах үйлдвэрээ барьж олсон ашгаа нийгмийнхээ хөгжилд, хүмүүсийнхээ амьдралыг сайжруулахад зориулна гэж ярьж суувал үлдэцтэй байж магадгүй. Манайхан Катар Азийн тоглолтод очиж ирээд их мөнгө хуваадаг юм байна гээд нийгэмд үлгэр болгож 500 000 доллар хармайлах тухай бодоод байх шиг.

Ш.Дашдаваа /Социологич/

Та сайхан санал тавьж байна. Харин одоогийн төр засаг үүнийг хүлээн авах магадлал хэр байна гэж та бодож байна. Би социологич хүн учраас эдийн засгийн нарийн зүйлийг мэдэхгүй. Гэхдээ олон түмний нэгэн адил миний хүлээлт бол дэлхийд ховор энэ том ордуудыг ашиглаад бидний амьдрал ахуй жаахан дээшлээсэй гэдэг хүсэл юм. Үндсэн хуульд тусгагдсан стратегийн зорилт гэж байгаа шүү дээ. Нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг бий

болгоно гээд. Нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг бий болгоход энэ ордууд яаж холбогдох бол?

Таны илтгэлийн нэр “Ашигт малтмалын ордыг үр ашигтай ашиглах асуудалд” гэж байна. Түүн дээр социаль үр дагавар гээд нэмчихвэл таны илтгэлийн бүтэц, гарах дүгнэлт ямар болж хувирах бол. Энэ талаар та бодсон уу?

Өнөөдөр сурсан зангаараа эдийн засгийн асуудлаа яриад л өнгөрнө. Сайхан тооцоонууд харагдаад байгаа. Хэрэв би андуураагүй бол олсон ашгаараа гаднаас зээлсэн өрөө бараг дарчих дайны юм харагдаж байна. Одоо миний нас явчихлаа. Та нартай зэрэгцээд ирж байна. Үлдсэн насандаа нэг аятайхан, хүний дайтай амьдарчихмаар байна. Тэгэхээр бидэнд энэ ордууд юу өгөх юм бэ? Энэ талаар юу гэж бодож байна? Энэ бол цогц системлэг асуудал. Та зөвхөн эдийн засгийн талаас нь ярилаа. Нийгэм эдийн засгийн систем гэдэг талаас нь асуудлыг авч үзэх боломж байсан уу?

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Таны асуусанд хариу өгье гэвэл тусгай судалгаа хийх хэрэгтэй. Энэ ордыг хэзээ ашиглах, үйлдвэрээ хэзээ байгуулж эхлэх, хэдийнээс хүчин чадлаа бүрэн ашиглах, хэзээ борлуулалтад гаргах вэ, ашиг нь хэзээ гарч ирэх вэ гээд судлах хэрэгтэй болно. Би үнэхээр ингэж судлаагүй. Бодлогын чанартай анхаарах асуудлаар л хязгаарласан.

Энэ бол мэдээжийн асуудал. Та тавин хэдтэй, би 75-тай. Үүнээс үр ашиг гараад хүртэнэ гэж горьдох юм надад байхгүй. Гэхдээ горьдохгүй гээд энэ асуудал дээр анхаарахгүй гэж гэдийхгүй. Үр хүүхэд, ирээдүйнхээ төлөө санаа зовж байгаа учраас хүртэх үү, үгүй юу гэдэг байр сууринаас хандахгүй байна. Харин хамгийн тодорхой зүйл гэвэл энэ ордуудыг ашигласнаар нийгмийн олон асуудлыг шийдэхэд тус дөхөм болно. Олон зуун мянган хүний амьдрал, олон мянган хүний ажлын байрны асуудал шийдэгдэнэ ээ. Энэ үр ашигтай үйлдвэрт ажиллах хүмүүсийн цалин хангамж илүү байж таарна. Гадны компаниуд хот байгуулах, нийгмийн асуудлыг шийдэхэд аль болох бага юм зарахыг л бодно шүү. Түр байшин бариад хот, аймгийн төвөөс хүмүүсийг зөөж 24 хоног, 17 хоногоор ажиллуулаад явуулчихна. Эдийн засагч хүмүүс учраас том барилга, хот босгохоос ихээхэн цааргална. Харин энэ талаар төрийн зүгээс бодлоготой хандах хэрэгтэй. Дэд бүтцээ байгуулах шаардлагыг сайн тавих хэрэгтэй. Тэнд ажиллагсдын ахуй амьдрал, орон сууц зэрэг асуудлыг аль болох иж бүрэн шийдвэрлэх шаардлага тавих ёстой байх. Тэгж л ажиллахаас өөр арга байхгүй.

Эндээс гарах ашгийг хишиг нэрээр бүх хүмүүст хуваана гэдэг бодлого буруу шүү. Энэ бол алсын хараагүй, ирээдүйгээ баллахад хүргэх үр дагавартай. Би үүнийг хатуу хэлж байгаа шүү. Зөв ч бай, буруу ч бай ерөнхийлөгчийнхөө хэлсэн үгнээс зөрж байгаадаа эвгүй л байна.

Үнэхээр Монголын эрх ашгийн асуудлаар хариуцлагатай байх ёстой учраас би үүнийг хэлж байна. Төсөвтөө төвлөрүүлэх хэрэгтэй. Харин төсвийн зардлаа ямар бодлогоор яаж ашиглаж эдийн засаг, нийгмээ хөгжүүлэх вэ гэдэг дээр Засгийн газар болон УИХ-д бодлого байх ёстой. Тэр нь зөв байх.

Ш.Дашдаваа /Социологич/

Таны хэлж байгаа чинь зөв л дөө. Харин одоогийн байгаа Засгийн газарт чадамж байхгүй. Таны саналыг хүлээн авах магадлал хэр байгаа бол?

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Таны хэлж байгааг боловсруулж болохгүй асуудал биш. Хийж болно. Өнөөдөр би үүнээсээ хэтэрч чадаагүй юм. Цаашдаа энэ талаар судлах бол би нэлээн их ажиллах ёстой. Техник, эдийн засгийн үндэслэлтэй их нарийн танилцах ёстой. Өнөөдөр төр ямар байна гэдэг тухай би тантай яримааргүй байна. Дутагдалтай ч юм бий. Гэхдээ шийдэх юмаа хийж л явна. Бид энэ төрийг дэмжих л ёстой юм шүү дээ. Тэдэнд туслах ёстой. Тийм л зорилгоор бид энэ ажлыг хийгээд явж байна. Харин шүүмжилчихээд өөрөө юу ч хийхгүй суугаад байж болохгүй.

Мөнх-Очир /Бодлогын судлаач/

Энэ том ордуудыг ашигласнаар олон зуун мянган хүний амьдралд яаж нөлөөлөх вэ гэдэг талаас нь ярьж байна. Би энэ том ордуудад дотоодын боловсон хүчнүүдийг ажиллуулах талаар өөрийн саналыг хэлбэ

гэж бодож байна. Өнөөдөр Эрдэнэтэд 5800 орчим хүн ажиллаж байгаа. Түүнээс 800-900 нь инженер техникийн өндөр мэргэжилтэй хүмүүс байна. Өөрөөр хэлбэл, Монголын инженерүүд ажиллаж байна гэсэн үг. Харин энэ ордууд дээр Монголын боловсон хүчнүүдээ ажиллуулах тал дээр төрөөс ямар бодлого барих ёстой вэ? Менежментийг нь гадны компаниудад хариуцуулахаар хаанаас ямар боловсон хүчнийг авч ажиллуулах вэ гэдэг нь тухайн компани шийдэх болно. Тэгээд дотоодын боловсон хүчнээ ажиллуулах боломж нь харьцангуй бага болчихоод байгаа юм.

Саяхны нэг мэдээллээр Дорнодын Тамсагийн орд газарт 3000 гаруй хятад иргэн ажиллаж байна гэсэн. Би Хөдөлмөр эрхлэлтийн газраас Монголд ажил эрхэлдэг гадаадын хүмүүсийн талаар судалгааны материал авсан. Тэнд бичсэнээр 6000 орчим гадны хүн ажиллаж байгаагаас 2000 гаруй нь хятад иргэн гэсэн тооцоо байна лээ. Энэ тоон мэдээллүүд чинь зөрөөд байгаа юм.

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Манай хуульд нийт ажиллагсдын 90 хувиас доошгүй нь монгол ажилчид байна гэж заасан байгаа. Энэ хуулийг хэрэгжүүлэхийн төлөө л ажиллах хэрэгтэй. Үүнийг их зөв чиглэлтэй хууль гэж боддог.

Менежментээ гадныханд өгөх нь монголчуудыг ажиллуулахад муугаар нөлөөлнө

гэсэн эргэлзээ байх шиг. Би тэгж бодохгүй байна. Эхний үед гадны өндөр мэдлэг, туршлагатай инженер, мэргэжлийн хүмүүс зайлшгүй ирж таарна. Бид ямар бодлого барих вэ гэвэл тэднийг дагуулж монгол залуусаа сургаж авах хэрэгтэй. Болгоомжлол байж болно. Үүнийг засч болох л асуудал. Хүнээ сургаж авах л хэрэгтэй. Оюутолгой, Тавантолгойд техник эдийн засгийн үнэлгээг хийж байх явцад л ямар мэргэжлийн хүмүүсийг бэлдэх хэрэгтэйгээ сонгоод сургах нь зүйтэй байх. Эрдэнэтийг анх байгуулахад маш олон Оросын мэргэжилтнүүд байсан. Өнөөдөр монголчууд дангаараа авч явж чадаж байгаа шүү дээ. Ингэж бид аажмаар хүнээ бэлдэнэ. 90 хувь гэдэг бол маш чухал. Үүнийгээ хатуу барих ёстой.

Ц.Дамиран /УИХ-ын гишүүн/

Зарим нэг зүйлийг тодруулъя. Ашигт малтмалын тухай болон 68 хувийн татварын хуулийг боловсруулахад би оролцож байсан. Төрийн өмчийн хөрөнгөөр нөөц нь тогтоогдсон бол 50 хувиас дээш байж болохгүй, 34 хувиас хэтэрч болохгүй гэсэн заалтыг сүүлийн үед нэлээн шүүмжлэх болсон. Үүнийг зүгээр л тэнгэрээс аваад тавьчихсан юм биш. Бид олон талаас нь ярьсан юм аа. Өнөөдөр манайд маш том ордууд байгаа. Бид 2.5 саяулаа. Зэс, алт, нүүрс, жонш, уран, төмрийн хүдэр гээд хэдэн гол түүхий эдээ боловсруулж бүтээгдэхүүн болгон гаргахад Монгол Улс маш амархан хөгжинө. Өнөөдрийн тулгамдаж байгаа нийгмийн асуудлаа шийдэж хойч залуу

үеэ боловсролтой болгоод Монгол Улсыг улсын дайтай хөгжүүлэх алтан боломжийн босгон дээр бид ирчихээд байгаа юм.

Төрийн өмчийн оролцоотойгоор нөөц нь тогтоогдсон бол, төр хувийн болон гадаад, дотоодынхонтой хамтарч оролцвол 50 хувиас хэтэрч болохгүй гэж байгаа. Төр дангаараа оролцох эрх нь нээлттэй. Өнөөдөр Монголд мөнгө байхгүй. Хэрвээ дотоод болон гадаадынхан энэ ордыг ашиглая гэвэл хөрөнгө оруулагчдыг үргээхгүй гэсний үүднээс 50 хүртэл байж болно, түүнээс хэтэрч болохгүй гэсэн заалтыг оруулсан. Төр 100 хувь дангаараа авч болох нь нээлттэй байгаа гэдгийг та бүхэн ойлгож үзээрэй.

Хайгуулын ажил маш их эрсдэлтэй байдаг. Энэ ордод илэрц байгаа эсэхийг мэдэхгүйгээр риск хийж ордог юм байна. Тийм учраас рискээ хийгээд явж байгаа тохиолдолд 34 хувиас илүү байж болохгүй юм байна, хөрөнгө оруулагчдыг үргээчих юм байна гэж яриад үүнийг оруулсан юм. Компанийн хуулийн 66 хувиас дээш нь шийдвэрээ гаргадаг гэдгийг барьж аваад 34 гэсэн тоог оруулж ирсэн. Хөрөнгө оруулж байгаа хүн энэ асуудлаа шийдэж байг ээ. Содном гуайн тооцоогоор 68 хувийн татвар авбал ашгийн 73 хувь нь Монголын талд ирэх юм байна. Ийм байдлаар хийсэн шүү.

Эцсийн бүтээгдэхүүн гаргах ёстой гэж Бямбасүрэн гуай хэллээ. 68 хувийн татварыг нэгдүгээрт, эцсийн бүтээгдэхүүн гаргах шат руу хөтөлж хийсэн юм. Хоёрдугаарт, зэсийн

үнийн сүүлийн 160 жилийн судалгааг, ойрын ирээдүйн хорин жилийн доторх прогнозыг авч үзэж судлаад гайгүй юм байна гэж хийсэн. Ойрын 4-5 жилдээ 5000 доллараас буухгүй юм шиг байна. Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ өсч байгаа юм байна. Хятадын эдийн засаг эрчимтэй хөгжиж байна. Нийт зэсийн хэрэглээний 26 хувийг Хятад хэрэглэдэг, бараг миллиард хүнтэй Энэтхэгийн зэсний хэрэгцээ жил тутам өсч байгаа. Манай Эрдэнэтийн зэсийн баяжмалыг цэвэр зэсэнд шилжүүлэхэд гарах зардал нь 1200 гаруй доллар байсан юм. Тэгээд 1300 болно гэж үзээд Эрдэнэт үйлдвэрт 100 хувийн ашиг үлдээж, түүнээс илүү гарсан ашгийг нь авч байгаа юм. Гэтэл “Айвенхоу Майнз”-ийнхан танилцуулгадаа нэг тонн цэвэр зэсийг 920 доллар гэсэн тооцоо хийж байсан. Тэгээд 2600 доллараас дээш авахад айхтар уначихгүй юм шиг байна лээ. Нөөц ашигласны татвар байна. Хэрвээ нүүрсийг дотоодын хэрэгцээнд, эрчим хүчинд хэрэглэж байгаа бол 2.5 хувь, бусад тохиолдолд 5 хувь гэж бодож хийсэн. Хэрвээ нүүрсний болон ашигт малтмал, барилгын материалын нөөц ашигласны татварыг нэмчихвэл орон сууцны үнэ, эрчим хүчний үнэ нэмэгдчих гээд байсан юм. Тийм учраас ингэж оруулсан. Гэхдээ илчлэг энэ тэр нь ямар байдаг гэдгийг эргэж харах нь зүйтэй байх аа.

Уул уурхайн салбарын ашгаас иргэддээ хишиг хүртээе гэж ерөнхийлөгчийн зүгээс ярьж байгаа. Иргэний хөдөлгөөнийхөн ч ярьж байгаа. Төсвөөр дамжуулж л өгнө шүү дээ.

Саяын тооцооноос үзвэл Монгол Улсад маш их ашиг байна. Хэдэн тэрбумаар олж байна. Үүнээс тодорхой хэсгийг нь нийгмийн салбарт л зарна шүү дээ. Арабын Эмират шиг иргэддээ өгөх гэдгийг ярьж л байж шийдэх асуудал. Би үүнийг дэмждэггүй. Төсвийн хуулийн дагуу л нийгмийн салбарт хандсан бодлогыг хэрэгжүүлэх ёстой. Нүүрс хөтөлбөр дээр ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Манайх 170 тэрбум тонн нүүрсний нөөцтэй. 2000-3000 жил түлээд ч барахгүй. Одоо дэлхийн зах зээл дээр үнэтэй байгаа дээр нь нүүрсээ бушуухан эцсийн бүтээгдэхүүн болгоод гаргах, мөн хүрэн нүүрс дээрээ түшиглэж том станц барин Хятад руу эрчим хүч экспортлох нь зүйтэй. Хятад улсад жил бүр 40 GB эрчим хүчний хэрэгцээ гарч байгаа. Ойрын 20 жилдээ ч буурахгүй гэсэн. Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр хэрвээ Монгол Улс эрчим хүчний эх үүсвэр шинээр баривал импортлоход бэлэн гэсэн ерөнхий тохиролцоо Хятад улстай хийсэн байгаа. Тийм болохоор Багануур, Шивээ-Овоогийн хүрэн нүүрс, эсвэл, Тавантолгойн нүүрсэн дээр тулгуурлаж том оврын станц хэдийг барьж Хятад руу эрчим хүч экспортолоход өртгөө дор нь нөхчихнө. Энэ талаар ярих нь зүйтэй гэж бодож байна.

Экспортын бүтээгдэхүүний үнийг төрөөс тогтоох нь ёстой буруу. Яг уурхай дээр байгаа нүүрсний үнэ, өөрийн өртөг хямдхан байгаа нь мэдээж. Нүүрсний үнэ уурхайд байгаа үнээрээ биш, тухайн хэрэглэгчид очиж байгаа үнээ шингээсэн байдаг гэсэн. Үүнийг тал талаас нь бодож ойлгохгүй бол болохгүй ээ.

Экологийн асуудал дээр би санал нэг байна. УИХ-ын хэдэн гишүүн Монгол Улсын усны хагалбар, усны болон ойн сав газарт 47-р өргөргөөс хойш ашигт малтмалын лиценз шинээр өгөхөө больё, харин одоо байгааг нь хуулийн дагуу шахалт үзүүлбэ гээд хуулийн төсөл санаачлаад явж байгаа. Одоогийн Ашигт малтмалын тухай хуульд байгаль орчныг хамгаалах талаар орон нутаг, тухайн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбараас дэмжлэг үзүүлэх олон заалт оруулж өгсөн байгаа. Дэд бүтцийг нь байгуулах, эрүүл мэнд, боловсролын салбарт нь тодорхой хэмжээний хөрөнгө оруулах гэдгийг тусгасан. Эцэст нь хэлэхэд ойрын хэдэн жилд уул уурхайн ордуудаа бариад зоригтойхон ашиглан мөнгө босгож нийгэм дэх бухимдлаа арилгаж, залуучуудаа боловсролтой болгон хөгжүүлэх сайхан боломж нээгдэж байна. Тийм учраас та бүхнийг энэ асуудалд саналаа нээлттэй хэлээрэй.

“Айвенхоу Майнз”-ын хувьцаа бидэнд хамаагүй гэж хэллээ. “Айвенхоу Майнз Монголиа” гэсэн компани байгуулсан гэж бид ойлгоод байгаа шүү дээ. Засгийн газрын хийж байгаа гэрээ ҮАБЗ дээр очоод дахин ярьж гээд буцсан гэсэн. Одоогоор УИХ-д орж ирээгүй байна. Орж ирэх үед нь энэ асуудлыг хөндөх ёстой. “Айвенхоу Майнз”-ын ашиглаж байгаа үйлдвэр бол бие даасан компани. Монголын 34 хувь оролцсон, “Айвенхоу Майнз”-ын 56 хувь оролцсон хамтарсан үйлдвэр байх ёстой. Түүний хувьцааг бие дааж бид зарах ёстой. Хөрөнгө оруулсан компанийн 10 хувийг монголчууд зарах ёстой.

Тийм хуультай шүү дээ. Үүнийг хөрөнгө оруулалтын гэрээ хийх үед тодорхой ярина.

Д.Бямбасүрэн /Ерөнхий сайд асан/

Би модон хууль гэж хэлсэн. Та бүхэн бас тайлбар тавьж л байна. Эрдэнэтэд 1300 доллар хүртэл, тэгээд 2600 гээд 100 хувийн ашиг өглөө гэж та сая хэллээ. Оросын тал зөвшөөрсөн юм байна. Гэтэл “Айвенхоу Майнз”-д 900 доллар байна гээд 2600 гэхээр 200 хувийн ашиг өгөв өө. Манайхан чинь яахаараа “Айвенхоу Майнз”-д унаад байдаг юм бэ. Тэгээд бас татвараа хөнгөлнө гээд яриад байдаг. Өөрсдийг чинь ярьж байхад л ойлгогдохгүй юм аяндаа гарч ирээд байх юм. Түүний оронд зардлын төдөн хувь давсан ашгаас төдөн хувийг нь авна гэж тохируулан хэлж болоогүй юм уу.

Алтыг та нар судаллаа гэж байна. Алтны үнэ дээд цэгтээ хүрч байх үед дэлхийн зах зээл дээр 393 тонн алт хэрэгцээтэй байсан. Энэ жил 209 тоннын илүүдэлтэй. Алтны үнийн уналт нүүрлээд байна шүү дээ. Эсвэл долларын ханшийн уналтаар нөхөгдөнө. Манай хуулиудад төдөн доллар гэж заадаг. Наад доллар чинь биднээс хамаарахгүйгээр хувирна шүү дээ. Үүнийг та нар бодлогын хэмжээнд ойлгох боломж байна уу.

Ц.Дамиран /УИХ-ын гишүүн/

Кинон дээр гардаг даа. Ардын засаг гэж хаа байдаг юм, авдаг өгдөг гэж ч хаа байдаг юм гэж. “Айвенхоу Майнз” байгуулагдах ч юм уу, үгүй ч юм уу. Тэр үед Фридланд 900 гаруй доллар гэж танилцуулж байсан.

Ний нуугүй хэлэхэд олж байгаа ашгийн 50 хувийг Орост өгөөд явуулчихгүйн тулд л хийсэн хууль шүү дээ. Эрдэнэт үйлдвэр байгуулагдсанаас хойш Монголд зэс хайлуулах үйлдвэр байгуулахыг огт дэмждэггүй байсан. Энэ тогтоол гарснаас хойш хоёр, гурван удаагийн хурал дээрээ зэс хайлуулдаг үйлдвэрийг Монголд яаралтай байгуулъя гэж асуудал тавьж байгаа. Цаана нь олж байгаа ашгаа Монголдоо авъя, эцсийн бүтээгдэхүүн болгоход бодлогоо хандуулъя гэсэн ерөнхий зарчим яваа. Цэвэр зэс борлуулах зардлаас зардлыг хоёр дахин өсгөж 100 хувийн ашиг үлдээн авахаар болсон юм. Өнөөдөр зэсийн баяжмал үйлдвэрлэдэг ганцхан үйлдвэр бол Эрдэнэт. Бид алтны компаниуд дээр чадахгүй байгаа. Зарим компанийн өөрийн өртөг нь 250 доллар, 300 доллар, зарим нь 450 доллар гэхээр яаж шийдэх арга байхгүй. Эрдэнэтийн үйлдвэр ганц учраас дунджаар нь тооцчихсон юм. Долларын ханш унавал тухайн үед нь хуульд өөрчлөлт оруулж болно шүү дээ. Хэдэн гишүүн санаачилж нэг чуулганаар хэлэлцчихнэ.

Д.Бямбасүрэн /Ерөнхий сайд асан/

Орд газарт байгалийн нөөцийн төлбөрийг 2 хувь, 5 хувь гээд тогтоож байгаа. Нүүрс гэхэд хүрэн нүүрс, чулуун нүүрс гээд, бас үе давхарга, нөөц, ашиглалтын зардлаараа харилцан адилгүй. Орд газрын төлбөр гэдэг нь нөөц ашигласан, концесс хэлбэрээрээ өөр. Орд газрынхаа онцлогийг тусгаж байгалийн нөөцийн үнэлгээний хувь хэмжээг тогтоож болдоггүй. Бүх юм дээр л 2.5 хувь,

эсвэл, 5 хувь гэдэг. УИХ-ын 76 гишүүн дотор хэдэн хувийг нааш цааш нь хөдөлгөж толгой нь эргэлддэг хүмүүс баймаар л юм. Та нар яахаараа ингэж хууль гаргадаг юм бэ. Тээвэрлэх зардал, байршил, дэд бүтэц, нөөц, агуулга нь ямар юм бэ. Бүх юм нь өөр шүү дээ. Ард талд нь бөөн сонирхол яваад байдаг. “Айвенхоу Майнз”-д 200 хувийн ашиг, Эрдэнэтэд 100 хувийн ашиг өгөөд л, “Айвенхоу Майнз”-ыг татвараас чөлөөлөөд явах юм.

Ц.Дамиран /УИХ-ын гишүүн/

Хууль хэлэлцэж байх үед Засгийн газраас ашигт малтмал бүрт өөр өөр байх тухай санал орж ирсэн. Нүүрс, жонш, төмөр гээд тус тусдаа өөр гэж.

С.Авирмэд

Би Бямбасүрэн гуайтай санал нэг байна. Ашигт малтмал бүр өөр. Тэгэхээр бүтээгдэхүүнд өөр өөр хувь оногдох ёстой байхгүй юу. Зэс хайлуулах үйлдвэр бол нэг өөр, түүхий эд гаргах бол нэг өөр, баяжмал гаргах бол нэг өөр, Баян-Өлгийд байгаа орд нэг өөр, Улаанбаатарт байгаа орд нэг өөр байх ёстой. Тийм зарчмыг бид оруулсан шүү дээ.

34 хувь, 50 хувь гэдэгт асуудал байгаа юм. Зарим хүмүүс намайг буруу ойлгодог. Төрийн оролцоо, төрийн өмч гэдгийг бид магтан дуулах гэсэн юм биш шүү дээ. Ингэж яс тоо заадаг нь дэлхийн практикт байхгүй болов уу гэж бодож байна.

Содном гуайн илтгэл бол яг хуулийн дагуу хийсэн илтгэл. Эдийн засагчийн хувьд сайн

илтгэл, сайн тооцоо болсон. Гэхдээ би Болдтой санаа нэг байна. Техник, эдийн засгийн үндэслэл биш, энэ бол баримжаа тооцоо. Бидэнд юу байгаа юм, бидэнд юу ногдох юм гэдэг талаасаа бодитой илтгэл болсон. Харин 2006 оны хуулийн дагуу хийдэг нь учир дутагдалтай юм. Өөр хувилбарууд байж болох юм. Бидний тэмцлийн үр дүнд Ерөнхийлөгчийн зүгээс энэ хуулийг дахин боловсруулах ажлын хэсэг гарч байгаа. Ер нь үйлдвэр, зохион байгуулалтын хэдэн хэлбэрээ л авах хэрэгтэй юм шиг. Энд үндэсний үйлдвэрээ, эцсийн бүтээгдэхүүнээ дэмжинэ гэдгээ хэлээд хамтарсан үйлдвэрээ ашиглавал нэг өөр, түрээсээ концессоор өгөх юм бол нэг өөр байна гэсэн бодлогоо л бид гаргана.

Сүүлийн үед цифрээр тоглодог моод их түгж байна. 68 хувь, 40 мянган айлын орон сууц, 250 сая гээд огт үндэслэлгүй цифрүүд. Түүгээр тоглож байна гэж би бодож байна. Цифрийг дандаа үндэслэж бай гэдэг хүмүүс энд сууж байна гэж би ойлгож байна. Онигоо хүртэл байдаг биз дээ. 68 хувийн татвар гэдгийг их аваргаа бодоод хийчихсэн гээд. Яагаад 70, эсвэл, 40 байж болоогүй юм.

Ашигт малтмалын хууль хоёр хувилбар орж ирсэн. Нэгийг нь Дамиран гишүүн санаачилсан талийгч О.Энхсайханы хууль, нөгөө нь ҮХЯ-ны Жаргалсайханы санаачилсан 1997 оны Ашигт малтмалын хууль тэр чигээр нь тавдугаар сарын эхээр оруулж ирсэн. Гэтэл зургадугаар сарын 29-нд нэр бүхий хэдэн гишүүн 34 хүртэл хувь, 50 хүртэл хувь гэдэг

цифрийг гэнэт оруулж ирсэн. Тэгээд сүүлд нь ийм будлиан болсон. Содном гуай 34 гэсэн дээд хязгаарыг нь аваад максималаар хийсэн байгаа юм. Хэрвээ 5 хувь бол, 50 хүрэхгүй хувь болчихвол шал өөр эдийн засаг гарна шүү дээ. Тийм магадлал бас бий. Тийм учраас энэ хуулийг ҮХЦ-д өгсөн байгаа. Дарга зассан гэдэг энэ хууль хүчингүй гэж би бодож байгаа. Нөгөөтэйгүүр энэ хууль Үндсэн хуулиа зөрчсөн. Төр өмчөө худалдаж авч байгаа юм биш гэж Содном гуай хэллээ. Төр хөрөнгө оруулсан. Жишээ нь, 34 хувь дээр 2.7 тэрбум доллар тавьчихаад байгаа шүү дээ. Хамаагүй өсчихсөн. Зөвхөн уурхай, баяжуулах үйлдвэр, дотоод цахилгаан хангамж, усан хангамж нь ороод.

Содном гуай Оюутолгой дээр 2.4 тэрбум, Тавантолгой дээр 4 тэрбум доллар тавьсан байна. Энэ нь бараг дэд бүтэцтэйгээ, зэсийн үйлдвэртэйгээ хамт байгаа болов уу гэж бодож байна. Болд эдийн засагчийн хэлснээр техник, эдийн засгийн нарийвчилсан тооцооны үндсэн дээр л гэрээ хэлэлцээрээ хийнэ үү гэхээс 40-50 хувь гээд өгчихсөнөөр хийвэл үндэслэлгүй юмаа дагаад эцэстээ алдана. Дашдаваа доктор асууж байна. Бидэнд юу унах вэ гээд. Содном гуайн хэлсэн дээр нэмэхэд Оюутолгойгоос 2 миллиард долларын бүтээгдэхүүн, Тавантолгойгоос миллиард, манай үндэсний бүтээгдэхүүн хоёр миллиард, бусад энэ тэр гээд тооцоход нийт 10 миллиард. Эдийн засаг хэд дахин өсч, дор хаяж эмч, багш нар 300-500 доллар аваад амьдрал өсөх бодит боломж харагдаж л байгаа. Үүнд хүрэхэд Ашигт

малтмалын энэ хууль чинь болохгүй байна гэдгийг энд давтан хэлбэ.

Л.Гунгаадорж /Ерөнхий сайд асан/

Хамгийн гол нь энэ илтгэлийн санаа УИХ, ЗГ, Ерөнхийлөгчид хүрч төр засгийн бодлогод ямар нэг хэмжээгээр тусвал ач холбогдолтой юм. Содном дарга эдийн засагчийнхаа хувьд өнөөдрийн баримталж буй Ашигт малтмалын хуулийн хүрээнд боломжийн хэмжээнд тооцоо хийсэн байна. Хүмүүс ярьж л байна. Өөр вариант гэж. Яахав гарч болох л байх. Өөрөө энэ хуулийн концепцтэй санал нэг байгаа учраас түүнийгээ л дагуулж хийнэ шүү дээ. Өөр ямар вариант байж болохыг энд байгаа мэргэжлийн хүмүүс ярих байх.

Авирмэдийн тавьсан асуултад Содном дарга хариуллаа. Энэ бол нэг нь асууж нөгөө нь хариулаад дуусчих асуудал биш. Газрын доорх баялаг тэнд хэвтэж байхдаа хэний ч юм биш. Тэгэхээр төрийн ч биш, хэний ч биш юм гэж бодож үзэх үү. Үүнийг тодорхойлоход мэргэжлийн хүмүүс, эрдэмтэд ажиллах асуудал байх болов уу. Үндсэн хуульд газрын доорх баялаг бүх ард түмний өмч гэж заасан. Түүний дагуу төр өмчөө худалдаж авна, авахгүй гээд маш их маргаан өнөөдөр яваад байгаа. Энэ бол сайн бодох асуудал. Бас нэг асуудал бол уул уурхайн салбарын хишгийг хэн хүртээд байгаа юм бэ гэж. Эрдэнэт хэдэн жил болов. Алт нэмэгдээд л байдаг, ард түмний амьдрал дээшилдэггүй, ядуурал 40 гаруй хувьдаа байж л байдаг. Энэ бол бүх иргэдийн, ялангуяа

жирийн иргэдийн санааг зовоосон асуудал болчихож. Ашигт малтмалын үр ашгийг ард түмэн яаж хүртэх ёстой юм бэ гэдэг их зовлонтой эд юм. Хишиг хүртээнэ гэж ярьж байна. Бас л нэг санаа. Үүнийг буруутгах арга алга. Нэг эрэл хайгуул явж байна шүү дээ. Улсын төсөвтөө төвлөрүүлээд түүнийг эргүүлж хуваарилах замаар явах байх. Зарчим бол тэр. Манай төсөв тэгж л хуваарилагдана. Тэгвэл яаж хүртэж байгаа юм бэ. Өнөөдөр хүртэхгүй, очихгүй л байгаа. Хэдэн эмнэлэг, сургууль гэсэн нийгмийн чанартай зүйлд зарцуулагдаж байгаа байх. Яг ард түмний ходоодонд нь, мөрөнд нь хувцас болж үзэгдэхгүй байгаа. Энэ их чухал асуудал шүү.

Содном даргын илтгэлд нэг санал бичиж өгсөн. Хоёр гол юман дээр төвлөрсөн учраас болоогүй байх. Монгол Улсын уул уурхайн салбарт ямар гол бодлого баримтлах юм бэ гэж глобаль бодлогын хүрээнд тодорхойлсон зүйл байдаг бол түүний дагуу л явах ёстой гэдэг санал. Энэ хоёр орд дээр хийсэн нь салбарын бодлогыг тодорхойлоход гол зүйл болж чадаж байгаа юу гэдэг асуудал байна. Өнөөдөр салбарын гол бодлого тодорхойгүй байгаа юм биш үү.

П.Жасрай /Ерөнхий сайд асан/

Саарал байшин дотор үндэсний хөгжлийн дунд хугацааны стратеги боловсруулж байгаа. Ерөнхийлөгчөөс гараад Засгийн газарт очсон гэсэн. Засгийн газар ерөнхийлөгч рүү буцаах гэж байгаа юм уу даа. Тэгээд өргөн барина гэсэн. Юу явж байгааг бид мэдэхгүй. Жинхэнэ

хаалттай юм тэнд явж байна. Тэгэхээр дэмий цаг үрсэн юм болчихож байгаа юм. Бидний илтгэлээс авмаар юм байвал түүндээ оруулвал зүгээр болов уу.

Манайхан тоо ярих их дуртай юм. Аргагүй л дээ. Социализмын үед ингээд сурчихсан юм чинь. Одоо Монголд байгаа тоо бол тоо биш. Сая бид жаахан оролдлоо. Нэг ч тоо олж чадаагүй. Тэгээд ямар дүгнэлтэд хүрэв гэвэл мэдээллийн бүх систем задарч унаад эдийн засгийн дүгнэлт хийх ямар ч аргагүй болчихсон гэж. Ерөнхийлөгчийн дэргэд үндэсний мэдээллийн системийг нэг сарын дотор боловсруулах ажлын хэсэг гарчихсан байгаа гэсэн. Тэр бүтэхгүй байх л даа. Тоо байхгүй, хөтөлбөр байхгүй болохоор ажиллахад хэцүү байна шүү дээ. Үүнд анхаараасай гэж бодож байна.

Нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тойрсон асуудал байна. 34 хувь, 50 хувь зөв үү, буруу юу гээд. Нэлээн маргаан явж байх шиг байна. Энэ дотор монголчууд л байгаа гэж бодож байгаа. Хятадын Гадаадтай харилцах эдийн засгийн хүрээлэнгийн хуралд би урилгаар очиж суусан. Тэдний хурлаас юу ч олж сонсохгүй юм байна лээ. Яам, газруудаар нь яваад ч юм сонсохгүй. Харин Өвөрмонголын сумууд дээр очиж хоноод жаахан дэлгэрэнгүй ярихад их аятайхан мэдээллүүд гарч байсан. Фридланд иймэрхүү юм хийсэн хүн байна лээ. Хятадад жижигхэн зэсийн ордыг лицензээр аваад зүүн хойд Хятадыг хөгжүүлэх гээд тэнд

гурван том цахилгаан станц барьж байгаа юм. Үенгийн тэндээс наашаа төмөр зам татаж байна. Хатан голын эхээс ус татаад Хатан голын ус, Тавантолгойн нүүрсийг тэр гурван станцад аваачиж шатаагаад тэр цахилгааны төлбөрт хэтдээ манай Тавантолгой, Оюутолгойн бүх зардал, валютын орлого яваад дуусах маягтай. Нэг тийм төлөвлөгөө хийсэн юм уу даа гэж би ойлгосон. Энэ бичлэгийг нь Элбэгдоржид, Энхбаярт авчирч өгсөн. Төрийн толгойд байгаа улс ийм юмыг харж байгаач, цаана чинь ийм бодлого явж байгаа юм биш үү гэдгийг хэлсэн. Тэд нар анхаарсан байх. Стратегийн орд гэдэг бүр будилуулчихсан байна. Одоо ДНБ-ий 5 хувиас дээш байвал стратегийн орд, доош байвал биш байх нь. Жишээ нь, уран стратегийнх биш, газрын ховор элемент стратегийнх биш. Хэмжээ нь л том бол стратегийн орд гээд гаргачихаж. Манай УИХ, ЗГ-ынхан үүнийгээ цэгцэлсэн нь дээр болов уу. Шалгуурыг нь тод болгомоор юм шиг. Миний санал бол орд бүр дээр үнэлгээ хийх хэрэгтэй. Агуулга нь хэд юм, хөрс хуулалтын коэффициент нь хэд юм, нийт нөөц нь хэд юм, ашиглалтын жил нь хэд юм, усаа хаанаас авах юм, тээвэр нь хаашаа явах юм гэх мэтээр орд бүр дээр тэгшитгэл хийгээд тооцчихож болно доо. Бямбасүрэн бид нар тухайн үедээ цаг шиг үнэ хийчихээд СнЗөвлөлөөр сайн л гүвүүлж байсан юм даг. Одоо бодож байхад тэр их л сайн байсан. Яг түүн шиг л хийх ёстой юм байна лээ. Тэгэхгүй бол бид хэзээ ч онохгүй. 34 хувь гээд яриад байдаг, аль нь ямар үндэслэлтэй юм, бүү мэд.

Орд тус бүр дээр маш тодорхой тэгшитгэл бодох хэрэгтэй.

Байгалийн баялгийг төрийн өмч, нийт ард түмний өмч гээд Үндсэн хуульд заачихсан. Тэнд нэг үгийн алдаа гарсан юм. Уг нь үндэсний баялаг гэдэг үгээр бичигдэх ёстой байсан. Тэгээд хайгуул хийчихсэн хойно нь нэг өөр юм байх учиртай. Манайхан Үндсэн хуульд гар хүрэх дуртай. Нэг удаа хүрээд засч болно шүү дээ. Жаахан засвар хийх далимаар нь засч болох байх.

Ард түмэнд юу очих вэ гэж ярьж байна. Тоо өссөн л юм харагдаад байдаг, гэтэл улам л ядуураад байна гэсэн яриа маш их гардаг. Янз янз л байгаа байх. Ийм бодлого барьж болно. Үндэсний цэвэр орлогын 50 хүртэл хувийг ажил хийсэн хүний түрүйвчинд хийгээд өгчих. Хувийн хэвшил, үйлдвэрлэл, эсвэл, төсвийн газар байна уу, хамаагүй. Түүнтэй зэрэгцүүлээд шууд бус татварыг буулгадгаа болиоч ээ. Энэ их утгагүй юм болоод байгаа юм. Гаалийн татварыг багасгалаа, нэмэгдсэн өртгийн татварыг багасгалаа гээд компаниуд баярлаж биднээс их ачаалал авчихлаа гэх юм. Ямар юм авч байгаа юм бэ, тэр чинь явсаар байгаад лангуун дээр хүрч худалдан авагчид төлж байгаа. Тэгэхээр түрүйвчинд нь хийдэг мөнгийг ахиухан өгчихөөд шууд бус татварыг нь бараа үйлчилгээндээ шингээгээд өгчихвөл яг л Солонгос, Америкийн хэмжээнд ирчихнэ. Монголд ажиллахад 600-700 мянган төгрөгийн цалин авч байна, бараа нь жаахан үнэтэй байна гэнэ. Тэнд байгаа хүмүүс тэгж л

ярьдаг шүү дээ. Бид тийм системд орохгүй бол явмааргүй юм шиг байна. Орд газраар 34, 50 хүртэл үү гэж шийдэхээс өөрөөр хөрөнгө оруулж хувьцаа худалдаад юм олж авна гэдэг худлаа. Тийм хөрөнгө ч Монголд байхгүй. Хувьцаагаа өгөхдөө байнгын хувьцааны ногдол ашиг өгдөг төлбөртэй болчихно. Зээл авчихаар зээлийн өр, дээр нь хүүгийн өр нэмэгдээд бүр баларна шүү дээ. Тийм учраас үүнийг улсын татвар, төлбөр, хураамжийн хэлбэрээр хийх хэрэгтэй байх. Гэхдээ хүн маргаж чадахгүйгээр нь хийх хэрэгтэй.

Р.Бадамдамдин /УИХ-ын гишүүн/

Манайх нэг хүнд оногдох GDP-ээр 1000 хүрээд л явж байгаа. Энэ бол ядуу орны хэмжээ юм. Түүгээр цалин, амьдралын түвшин тодорхойлогдоод явж байгаа. Хоёр, гурван том орд ашиглалтад орчихвол нэлээн хэдэн мянгад хүрчих бололцоотой. Амьдралын түвшин нэмэгдэх байх. GDP-ийн хуваарилалтыг авч үзэхээр их сонин зүйл гардаг юм. Өнгөрсөн жил татварын хууль батлах гээд дэлхийн олон орны татварын байдлыг судалж үзсэн. Төсвийн хэмжээ GDP-ийнхээ хэдэн хувийг эзэлж байна гэж үзэхэд манайх шиг нэг хүнд ногдох GDP нь 1000 орчимд байгаа ядуу орнуудын хувьд 20-иос хэтрэхгүй, дээд тал нь 24 байна. Хятадын төвлөрсөн төсвийн хэмжээ GDP-ийнхээ 18 хувьд байна. Нэг хүнд оногдох GDP 30 болон түүнээс дээш болчихсон Европын орнууд, Америкт төсөв нь нэлээн өндөр байдаг юм билээ. 44 хувь хүрсэн тохиолдол байна. Манайх ядуу орон дотроо ганцаараа л төсөв нь GDP-ийнхээ 50 хувьд хүрчихсэн байгаа юм.

Хуулиараа том том ордоо төрийнх эзэмшилд аваад төрийн авах юмыг нэмэгдүүлэхээр төсөв нь их том болж, социализм байгуулж байгаа дүр төрх харагдах нь л дээ. Социализмын үед бүх өмчийг төр нь аваад, төр нь ашгаа эргэн хуваарилдаг байлаа. Тийшээ нэлээн ойртох дүр зураг харагдаж байгаа юм. Энэ нь дэлхийн чиг хандлагатайгаа таарч байна уу гэдэг нэг асуудал байна. Одоо ч хүртэл социализмаа байгуулсаар байгаа орон байна. Куба, Хойд Солонгос гээд. Эднийг харж байхад нэг их амжилт олохгүй нь харагдаад байна. Тэр хандлага нь сонголт байх.

Бямбасүрэн гуай байгаль орчноо цаашид яах вэ, уул уурхайгаа бодлоготой хөтлөхгүй бол сүйрэлд хүрч мэднэ шүү гэсэн чухал асуудлыг хөндөж байна. Энэ бол үнэхээр анхаарвал зохих чухал асуудал юм.

GDP-ийнхээ ихэнхийг аваад байдаг. Байгаль орчин нь нүдэн дээр сүйдээд байдаг. Саяхан хүртэл янз бүрийн юм гарч байна. Үүнийг хараад элэг нь эмтэрч тийшээ мөнгөө өгөөд л байдаг, өгөөд л байдаг. Гэтэл байгаль ч сүйдсэн хэвээрээ, хүмүүс нь ч ядуугаараа үлдэх юм биш биз гэсэн болгоомжлол байна.

Ашигт малтмалын хуулийг боловсруулах үед гадаад орнуудын туршлагыг судалж байлаа. Дугуйг шинээр зохиодоггүй гэдэг нь хэнд ч тодорхой шүү дээ. Бид Австралид очсон. Тэнд төрийн оролцоо гэж байхгүй, төр татвар авах, байгаль орчны нөхөн сэргээлтэд нь өндөр

шаардлага тавьж хянах үүрэг гүйцэтгэдэг. Компаниуд нь их бие даасан байдлаар ажлаа явуулдаг юм билээ. Орон нутаг нь их эрх мэдэлтэй, татварын ихэнх нь орон нутагт оногддог, бага хэсэг нь төвлөрсөн төсөв рүү ордог. Ард түмний баялаг хуваана гэсэн ойлголт байхгүй. Канадад ч, Австралид ч адил. Үүнийг өөрийнхөө онцлогт тохируулаад явах байх.

Африкийн орнууд ашигт малтмалаар баян. Тэнд төрийн оролцоо байх ёстой, ард түмэн ядуу байна гэж байгаад их өндөр татвар, оролцоо, мөнгө авдаг шиг байгаа юм. Харин эргээд түүнийгээ хуваарилж чаддаггүй. Ард түмэн ядуугаараа үлдэнэ, удирдагчид нь баяжиж завшаад явчихдаг тохиолдол нийтлэг маягтай. Өмнөд Америкийн орнуудад бас тийм тохиолдол байна. Манайх тийм замаар нь явчих гэж байгаа юм биш биз. Ард түмнийгээ хайрлаж өрөвдөж, тэдний төлөө хашгирсаар байгаад хашгирсан хүмүүсийн үр дүн дээр нь өөр хүмүүс хожих, төрийн түшмэдүүд эрх мэдэл аваад хуваарилалтыг буруу хийх вий гэсэн болгоомжлол байх юм. Энэ бүгдийг санал солилцох журмаар хэлж байна. Саяын ярьсан хүмүүсийн ихэнхтэй нь санал нэг байна.

Уул уурхайн салбарын ил тод байдал гээд олон улсын хэмжээнд явагдаж байгаа санаачилгад нэгдэн орох хэрэгтэй. Тэгээд ямар ашиг хаанаас гараад хаана хуваарилагдаж, яаж яваад байгаа нь ард түмэнд ойлгомжтой, дуртай цагтаа энэ мэдээллээ авч байдаг, хянаж байдаг ийм л төр байх ёстой. Тийшээ л явах ёстой гэсэн бодол байна.

Д.Бямбасүрэн /Ерөнхий сайд асан/

Монголдоо социализм байгуулж байна гэж та сая ярилаа. Содном гуайн Засгийн газрын үед төсвийн зарлага үндэсний нийт бүтээгдэхүүний 33 хувь байсан. Манай Засгийн газрын үед 26 хувь болгож бууруулсан. Одоо 40 гараад явж байна. Энэ социализмыг хэн байгуулаад байна аа.

Бадамсүрэн /ҮХЯ-нд Геологи, уул уурхай хүнд үйлдвэрийн газрын дарга/

Шинээр батлагдсан Ашигт малтмалын тухай хууль болон өнөөдрийн Монгол Улсад мөрдөгдөж буй уул уурхайн бизнес эрхлэх энэ орчны хууль тогтоомжийн хүрээнд тодорхой тооцоо гаргаж ярилаа. Тавантолгой, Оюутолгойн орд Монголын ард түмэнд, Монгол Улсын хөгжил дэвшилд ямар хувь нэмэр оруулах вэ гэдэг харьцааг их ойлгомжтойгоор тодорхойлон ярьсан Содном гуайд гүн талархал илэрхийлж байна.

Ер нь цөөхөн монголчууд бидэнд энэ салбар үр өгөөжөө өгнө өө. Бид тал талаас нь хэлэлцэн ярилцаж байгаад энэ салбарын талаар цэгцтэй ойлголттой болчихвол тустай юм гэдгийг тэмдэглэн хэлмээр байна. Энэ салбарыг үр өгөөжтэй хөгжүүлэх асуудал яригдаж байна. Хамгийн гол нь төрөөс баримтлах урт хугацааны, алсын хараатай, цэгцтэй бодлого их чухал юм. Тийм учраас ҮХЯ-наас эрдэс баялгийн салбарт урт хугацаанд баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулсан. Нэгдүгээр үе шат

нь 2007-2015 он, хоёрдугаар үе шат нь 2016 оноос цаашаа хэрэгжүүлэх хөтөлбөр юм. Энэ баримт бичигт геологийн салбар, уул уурхайн салбарын боловсруулалтын түвшний асуудал, энэ салбарыг хөгжүүлэхэд ямар бүтэц, зохион байгуулалт байх ёстой, яаж сайн менежмент явуулах ёстой, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол Улсын хөгжил дэвшил, ард түмэнд, тухайн бүс нутагт юу үлдэх юм гэдгийг тусгасан. Засгийн газраар газрын тосноос бусдыг нь хэлэлцүүлсэн, одоо УИХ-аар хэлэлцэх гэж байна. Энэ баримт гараад ирвэл салбар маань аятайхан хөгжих байх гэж найдаж байгаа.

Уул уурхайн салбар дээр улс орныхоо хөгжлийг харж ажиллавал илүү боломжтой гэж ойлгогдож байгаа. Ялангуяа дэд бүтэц, эрчим хүчний хангамж, зам харилцааны асуудал байна. Баяжуулах үйлдвэр гэхэд усны асуудал гээд. Үүнтэй уялдаж байгаль экологийн асуудал гарч ирнэ. Их ойлгомжтойгоор хэлбэл, уул уурхайн үйлдвэрүүд гарын таван хурууны зарчмаар ажилладаг шүү дээ. Геологийн судалгаанаас нь эхлээд уурхайгаа хааж нөхөн сэргээх хүртэл энэ асуудалд цогцолбороор хандах ёстой гэсэн хувийн бодол байдаг.

Бид зам харгуй, хөрөнгө оруулалтын асуудлыг шийднэ. Өнөөдөр салбарын хэмжээний нэлээн том асуудал бол боловсон хүчин байгаа. Тэнд ажиллах мэргэжлийн ажилтан ч, инженер техникийн ажилтан ч дутмаг. Тийм учраас яамны зүгээс боловсон хүчнээ бэлтгэх талаар их, дээд сургууль, үйлдвэрүүд болон хөрөнгө

оруулагч нартайгаа хамтраад хийе гэж төлөвлөж байгаа. Монгол хүн ажиллах ёстой гэж хүн бүр ярьж байгаа. Гэвч бэлтгэх тал дээрээ бид анхаарах ёстой.

Тавантолгойн нөөц нь батлагдсан. Төмрийн хүдрийн ордууд бас нөөц нь батлагдсан байгаа. Өнөөдөр тодорхой төслийг ярихад голдуу гадны хүмүүсийн санал яваад байдаг. Гэтэл Монголын талын санал тодорхой байх хэрэгтэй юм шиг санагддаг. Монголын Засгийн газрын саналыг тойрч бусдын саналыг нь авч явах ёстой юм болов уу гэж бодож байгаа.

С.Оюун /УИХ-ын гишүүн/

34 хувь хүртэл гээд улсаас мөнгөө босгож оролцоно гээд ярьж байгаа. Түүний оронд болдогсон бол 10-15, эсвэл, 20 хувийг өөрсдөө мөнгө оруулахгүйгээр үнэгүй авчихмаар. Тэгээд татвараа, үнэгүй хувийнхаа ногдол ашгийг аваад зовлонгүй л амьдармаар санагдах юм. 34 хувийг үнэгүй авчихъя гэхээр хөрөнгө оруулагчдад ашиггүй болж таарах байх. Эдийн засгийн ашиг нь 12-22 хувь гэж ярьдаг шүү дээ.

Хайлуулах үйлдвэр барихад ашигтай юм шиг боловч байгаль орчинд халтай байдгийг мартаж болохгүй. Америкийн зарим штат зэсийн хайлуулах үйлдвэр барих зөвшөөрөл өгөхөө больсон гэнэ лээ. Тухайн үед нь байгаль орчиндоо халтай эсэхийг анхаарах хэрэгтэй.

Б.Булгамаа /Сэтгүүлч/

Надад нэг ойлгомжгүй асуудал байна. “Айвенхоу

Майнз”-ийн Засгийн газартай хийсэн драфтан дээр гүний ус ашиглана гэж заасан байгаа юм. Нөгөө хувилбар дээр нь Сэлэнгэ юм уу, Хэрлэн голоос ус татна гэж ярьж байгаа. Үүнээс өөр ямар хувилбар байгаа юм бол оо.

П.Жасрай /Ерөнхий сайд асан/

“Айвенхоу Майнз”-ын тэнд гүний ус ерөөсөө байхгүй шүү дээ. Хайгуул хийсэн юм байхгүй. Хатан голоос ус татаж аргацаах гэсэн юм байж магадгүй. Харин наана Чойрын хавьд хоёр ойрхон, нэлээн сайн чанарын, олон жил хэрэглэх усны нөөц байгаа. Гуравт нь, Онгийн голоо сэргээх хэрэгтэй. Тэгвэл Цагааннуур сэргэнэ. Цагааннуур сэргэвэл Цагааннуурын урд талын хайгуул хийчихсэн усны нөөц сэргэнэ. Ийм л гурван эх үүсвэр бий. Хэрлэн гол тийшээ явна гэж битгий бод. Тийшээ явахгүй.

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Оюутолгойн тэр хавьд гүний ус нэлээн хайсан юм билээ. Миний ойлгосноор гүний усны нөөц байна гэж тооцож байгаа гэсэн. Гүний усыг ашиглах нь зөвшөөрөх санал биш гэдэг дээр тантай санал нэг байна. Гүний усныхаа нөөцийг хүчтэйхэн шиг сороод байвал мал усалдаг хэдэн худаг энэ тэр чинь алга болохоос эхлээд аюул нүүрлэх байх.

Харин Хэрлэнгээс урагшаа ус татах гэдгийг хамгийн зөв санал гэж бодож байна. Гэхдээ энэ хүмүүс буруугаар яриад байгаа юм. Хэрлэнг тасалж аваад цааш нь Далай нуур луу цутгахгүй

болгоод тэгээд л урагшаа авчих юм шиг зүйл яриад байгаа юм. Тэр бол буруу. Энэ талаар усны мэргэжлийн хүмүүс нь тооцоо хийн төсөл боловсруулж байгаа юм билээ. Ердийн урсгалыг нь хэвээр байлгана. Тэгээд үерийн ус, бороо, цасны илүүдэл усыг нь хоёр гурван газарт нөөцөлж байгаад тэндээсээ говь руугаа трубагаар татах юм билээ. Энэ хангай нэг жаахан усаа говийнхноосоо харамлаад хэрэггүй байх л даа. Технологийн зөв горимыг нь л бодох хэрэгтэй. Энэ нь их зөв санагдаж байгаа.

С.Авирмэд

Усны хангамжийн асуудал шийдэгдчихсэн шүү дээ. Усны хайгуул хийгээд 40-80 км зайд Гүний хоолой гэдэг газарт 100-200 метрийн гүнд усны том бассейн олсон. Тэр ус нь чанарын хувьд давстай, ундаанд хэрэглэх боломжгүй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэсэн. 10 метр хүртэл гүнд байгаа бол байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлнэ, харин 100 гаруй метрийн гүнд байгаа учраас байгаль орчинд нөлөөлөхгүй, тэнд санаа зовох хэрэггүй гэж усны мэргэжилтнүүд ярьж байна лээ.

Ц.Мөнхбаяр /”Онги гол” хөдөлгөөний тэргүүн/
Түрүүнээс хойш ийм л зүйлийг хүлээгээд байсан юм. Саяын асуулт тавьсан охинд их баярлаж байна. Яг үнэндээ бид байгаль орчиндоо халгүйгээр үйлдвэрлэл явуулах асуудлаа эхэлж ярихгүй бол болохгүй ээ. Их сайхан зүйл ярьж болно. Маш их нөөцтэй, дэлхийн эхний топ 10-д орсон, нөөц маань тогтоогдчихсон, олон улсын анхаарлыг татсан,

хөрөнгө оруулагчдын анхаарал яг төвлөрсөн байгаа энэ ордуудыг үр өгөөжтэй ашиглаад улс орноо хөгжүүлэх тухай ярилгүй л яахав. Үүнийг үгүйсгэж байгаа юм биш.

Нэг зүйл ер ойлгогддоггүй юм. Монгол орны өөрийнх нь онцлог, байршил гэж байгаа. Энэ цэнхэр гарагийн хамгийн том эх газрын төв дэх ганцхан л орон шүү дээ. Эх газрын хуурай, эрс тэс уур амьсгалтай гэдгийг бүгдээрээ мэднэ. Манай улс орны маань онцлог, байгаль маань энэ уул уурхайн үйлдвэрүүдийг аваад явчих чадвартай юу. Ямаан дээр тэмээний гарз гэдэг үгийн логикийг сайн мэддэг ард түмэн шүү дээ, бид. Энэхэн үедээ баяжчихаад хамгийн хөгжилтэй улс орон болж болно. Их бүтээн байгуулалтыг хийчхээд түүний цаана хүмүүс яаж амьдрах вэ гэдгийг бодохгүй байх эрхтэй гэж үү. Тийм байх ёсгүй. Энэ бодитой зүйл дээр тулгуурлаж хамгийн түрүүнд Монгол орныхоо экологийн онцлог байдлыг харгалзаж үзсэн, байгалийнхаа бодитой даацан дээр тулгуурласан бодлогын тухай ярихгүй бол хөгжлийн тухай энэ яриа бол эмгэнэл шүү. Ийм бодлого байгаа бол болно оо. Зөвшөөрнө. Далай лам “шинжлэх ухаан сүнс байхгүй гэдгийг баталчих юм бол би 100 хувь гараа өргөө” гэж хэлсэн биз дээ. Тэгвэл Монгол орны байгалийн чадавх, даацыг тодорхойлчихсон уул уурхайн хөгжлийн бодлогын тухай яривал би 100 хувь зөвшөөрнө.

ГАРЧИГ

Монгол улсын ашигт малтмалын ордыг үр ашигтай ашиглах асуудалд.....	1
Байгалийн баялаг хяслан болох учиргүй.....	1
Олборлох салбарын ил тод байдлын санаачлагын ач холбогдол.....	2
Хууль боловсронгуй болгох асуудалд	3
Ашигт малтмалын тухай болон татварын тухай хуульд зарим өөрчлөлт оруулах шаардлагын талаар.....	4
Төрийн оролцооны талаар.....	5
Монголын үндэсний компанийг дэмжих бодлогын талаар.....	7
Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордын ашиглалтаас төрд орж ирэх ашиг хуримтлалын хуваарилалт ашиглалтын талаар.....	9
Мөнгөний худалдан авах чадварт гарч болох өөрчлөлт	10
Ашигт малтмалын ордыг ашиглах зохистой хэмжээ ба боловсруулах үйлдвэр	10
Ашигт малтмалын ордын бүтээгдэхүүний экспортын үнэ орлогыг хянах асуудал	12
Ашигт малтмалын стратегийн ач холбогдолтой гэж үзэж буй алт зэс, коксжих нүүрсний зарим ордын ашиглалтаас орж болох ашиг хуримтлал болон түүний хуваарилалтад хэрэглэх нөхцлүүдээр хийсэн баримжаа тооцоо, түүнээс хийж болох дүгнэлт санал.....	14
Оюутолгойн зэс алтны ордын эдийн засгийн үзүүлэлт, ашиг хуримтлал, түүний хуваарилалтын баримжаа тооцоо, түүнээс хийх дүгнэлт, санал	19
“Ашигт малтмалын ордыг үр ашигтай ашиглах асуудалд” санал зөвлөмжийн гол агуулга.....	21
Лекцийн тэмдэглэл	22